



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР**

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон,  
Сүхбаатарын талбай 6, Утас: 26-30-83, Факс: 26-12-73  
E-mail: Office@president.mn

2014. 07 28 № ТГ/534

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Б.БОЛДБААТАР ТАНАА**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн 2013 оны үйл ажиллагааны тухай танилцуулгыг хүргүүлэв.

Хавсралт 40 хуудас.

ДАРГА



П.ЦАГААН

00947

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
2013 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТАНИЛЦУУЛГА

(2013.01.01-2013.12.31)

Улаанбаатар хот

Төрийн ордон

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин тавдугаар зүйлийн 35.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн 2013 оны үйл ажиллагааны талаар Улсын Их Хуралд танилцуулж байна.

2013 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуульд Цахиагийн Элбэгдорж нэр дэвшин Ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхийн санал авч хоёрдахь удаагаа Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон.

2013 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Цахиагийн Элбэгдоржийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай хуулийг хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүд 94,4 хувийн саналаар баталсан. Мөн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөр дахин сонгогдсон Цахиагийн Элбэгдоржийн тангараг өргөх ёслолыг долдугаар сарын 10-ны өдрийн 11:40 цагт хийх шийдвэр гаргасан.

Ийнхүү 2013 оны 07 дугаар сарын 10-ны өдөр Цахиагийн Элбэгдорж Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөж Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин хоёрдугаар зүйлийн 32.1-д зааснаар бүрэн эрх нь хэрэгжиж эхэлсэн болно.

**НЭГ. ТӨРИЙН БАЙГУУЛАЛ, УЛС ОРНЫ УДИРДЛАГЫН ТАЛААРХИ  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХИЙН ХҮРЭЭНД**

Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч, Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөлийн тэргүүний хувьд иргэд, олон нийтийн сэтгэлийг зовоосон, шийдлээ хүлээж буй олон асуудлыг улс орон, төр засаг, ард түмний нийтлэг эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэх үндсэн зарчмыг баримтлан хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүдтэй ажлын уулзалтууд хийж тодорхой асуудлууд дээр санал солилцож, үүрэг зөвлөмж өгч ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлын чуулганд өөрийн тааллаар оролцон улс орны дотоод, гадаад байдлын нэн чухал асуудлаар мэдээлж, төрийн бодлогын аливаа асуудлаар Улсын Их Хуралд саналаа оруулах бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч 2013 оны 01 дүгээр сард Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөлийн тэргүүний хувьд Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын гишүүдэд хаалттай мэдээлэл хийлээ.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч 2013 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн нээлттэй хуралдаанд Засгийн газраас Оюу толгойн асуудлаар хийсэн мэдээллийг сонсож, зарим зүйлийг тодруулж асуун өөрийн байр суурийг илэрхийлж оролцлоо.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2013 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Улсын Их Хурлын хаврын чуулганы нээлтэд (“Эрх чөлөө, эх орон хоёр минь бүтэн байг ээ”) үг хэллээ. Монгол Улсын Ерөнхийлөгч хэлсэн үгийнхээ эхний хэсэгт,

- ... Хүмүүс өөрчлөгдөж байна. Энэ өөрчлөлт зөвхөн Монголд биш дэлхий нийтэд болж байна. Монголчууд асуудалд бусдын заавраар бус өөрийн үнэлэмжээр ханддаг болж байна. Өөрийн гэсэн үнэлэмжтэй бүхэл бүтэн үе Монголын нийгэмд түрэн орж ирж байна...
- ... Хүмүүс шийдэлд, ажилд оролцохыг хүсэж байна. Иргэд оролцоод асуудал шийдээд ирэхээр шийдэл амьдралд ойртож байна...
- ... Хуулийн засаглал тогтож эхэлж байна. Монгол Улс даргын засаглалтай биш, хуулийн засаглалтай орон болж байна. Манай иргэд төрөөс бурууд хатуу, зөвд зөөлөн байхыг нэхдэг боллоо...
- ... Монгол Улсын нэр хүнд өсч байна. Дэлхийн хамтын нийгэмлэг ч үүнийг үнэлж байна. Монголын нэр дэлхийн сонорт хүрлээ. Хүний хууль ёсны эрхийг дээдлэх, хуулийн засаглалыг хэрэгжүүлэх, иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах Монгол Улсын бодлого бүс нутагтаа төдийгүй, олон улсад талархал хүлээж байна...
- ... Нийгэмд олон зүйл эмх цэгцэндээ орж байна. Монгол Улсад тулгамдаж байгаа олон хүндрэл бэрхшээл бий. Хамгийн гол нь тэр хүндрэл бэрхшээлийг бодитой харж, бас ний нуугүй хэлэлцэж чадаж байгаа нь Монгол Улсын ололт юм. Бид бүгдээрээ алдаа дутагдлаа хэлэлцдэг боллоо хэмээн

улс оронд маань юу болж бүтэж байгаа, амжилт ололтын тухай, түүнийг хэрхэн бататгах талаар дүгнэн ярьсан бол харин удаахь хэсэгт нь,

- ... Асуудлыг шийдэхдээ хүнээ мартаад байна. Ялангуяа асуудал шийдэхэд цөөнх болоод байгаа хүмүүст хүний эрхээ эдлэх, асуудлаа шийдүүлэх боломж нь байнга нээлттэй байх тухай яриад эдгээрт шийдэл бий. Олон оронд үүнийг шийдээд ирсэн сайн туршлагауд ч бий. Гагцхүү түүнийг ойлгох сэтгэл, цэгцтэй бодлого хэрэгтэй байна гэлээ.
- ... Монголын төр бүтээгчдээ дэмжихгүй байна, хөрөнгө оруулагчид баялаг үйлдвэрлэгчиддээ хандсан тогтвортой, тодорхой бодлогогүй явж ирлээ. Хөрөнгө оруулалтын тогтвортой орчин алга байна. Дотоод гадаадгүй хөрөнгө оруулалтад тогтвортой, тодорхой Монгол Улсын бодлого, хууль хэрэгтэй байна. Хөрөнгө оруулагчид тэр бүр татварын хөнгөлөлт хүсэхгүй байна. Улсын бодлого, хууль тууштай тогтвортой байхыг л харж байна. Бодлогоо тогтвортой, тодорхой болгоё. Улаанбаатарт, эсвэл орон нутагт хичнээн хөрөнгө оруулбал хэдэн жил тогтвортой байхыг баталгаажууъя. Уул уурхай, дэд бүтэц,

үйлдвэрлэл, эсвэл эрүүл мэнд, боловсрол, өндөр технологид оруулсан ямар хөрөнгө, ямар хугацаанд тогтвортой байхыг хэлж өгье. Уг хуулийг тогтвортой хэлбэрэлтгүй мөрдөнө гэдгийг баталгаажуулж өөрчлөлт оруулах босгыг нь ч тусгайлан өндөр хувиар зааж өгье. Жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчид ажлын байр бий болгож байгаа, тэр тусмаа 40-өөс дээш насны эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг авч ажиллуулж байгаа бол жижиг, дунд бизнес эрхлэгчдэд хөнгөлөлт үзүүлэх хэрэгтэй. Хот хөдөө, салбар орчин нөхцөлд нь тохирсон тодорхой тогтвортой бодлого гаргая. Энд шийдлүүд, гарц бий. Ингэж чадвал Монгол Улс хөрөнгө оруулахад бизнес эрхлэхэд ээлтэй орон болно.

- ... Бид төрөө засалгүй уджээ. Төр томорч байна. Бидний нэн даруй засах ёстой нэг алдаа бол энэ. Төрийн зардлын хэмжээ нэмэгдэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх жин нь жил ирэх тусам өссөөр байна. Нийгмийн амьдралд төрийн хэт оролцоог багасгах хамгийн сайн арга бол эрхийн шилжилт юм. Иргэдэд, олон нийтийн үүсгэл санаачилгын, мэргэжлийн болон бизнесийн байгууллагуудад төрөөс хуульчилж, шат дараатай шилжүүлэх олон эрх, үйлчилгээ бий. Хуулийг нь баталж, жагсаалтыг нь гаргаад энэ ажлыг хурдан эхэлье. Дарга, сайдуудын тушаал захирамж гаргадаг замбараагүй эрхийг хуулиар журамлах ёстой. Ер нь шинэчлэл хийх гэж байгаа бол эхлээд хуулиа өөрчил, дүрмээ өөрчил. Түүнд зохицож ажиллахыг албатуудаасаа шаард. Гэхдээ даргад таалагдахгүйг бус харин иргэнд таалагдахгүйг өөрчлөхийг шинэчлэл гэж байгааг сана.
- ... Өөр бас нэг алдаа бол нийгэмд бий болж байгаа баялаг нийтийн хүртээл болж чадахгүй байна. Баялаг бүтээх үйлсэд иргэдээ оролцуулах үүд хаалгыг л нээх хэрэгтэй. Баялаг нэг хүнийх, нэг бүлийнх байнга байх боломжгүй. Аливаа баялаг нийтийн шинж чанартай байдаг. Түүнийг албажуулах, амьдралд буулгах л хэрэгтэй. Манай оронд бий болж байгаа нийт баялгийн 95-аас илүү хувь нь цөөн гэр бүл, эсвэл цөөн дарга нарын, эсвэл төрийн мэдэлд байна. Үнэт цаасны болон хөрөнгийн биржийн шаардлагатай хуулийг хурдан гаргая. Дотоод гадаадгүй Монголд орж ирж байгаа баялаг бүтээгчид тэр баялгаа Монгол Улсын иргэдтэй хамтарч бүтээцгээ.
- ... Байгаль орчиндоо хүйтэн цэвдэг хандсаар байгаа нь бид бүхний уучилж боломгүй алдаа шүү гэдгийг би иргэддээ хэлэх гэж бодсон юм. Улаанбаатарын утааг зун ч мартаж болохгүй гэж боддог. Говь талын усны асуудал манай хөгжлийн хамгийн хурц, хамгийн ээдрээтэй асуудлын нэг болж босож ирж байна. Байгалиа, орчноо хамгаалах өөд татах бодлого үйл ажиллагаанд иргэд оролцвол бас зөв болно. Энэ бодлогыг даргын мэдлээс иргэний мэдэлд шилжүүлбэ гэдэг бол энэ салбарын ажлыг цоо шинэ, бүтээлч шатанд гаргана гэсэн үг. Явж явж хүрээлэн буй орчинтойгоо зохицож, тэр орчноо өөд татаж амьдрахыг л зөв бодлого гэж хэлээд байгаа юм. Монгол Улс байгальд ээлтэй хөгжилд, технологид, санаачилгад хөрөнгө зарах хэрэгтэй ... хэмээн хэлээд

бид юун дээр алдаж байгаа тухай, мөн алдаагаа яаж хэрхэн засах талаар саналаа хэллээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2013 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 6-д “Хууль санаачлах бүрэн эрхийнхээ дагуу боловсруулсан хуулийн болон түүнтэй холбогдох шийдвэрийн төслийг хууль тогтоомжид заасны дагуу Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлнэ” гэж заасны дагуу дараах хуулийн төслийг боловсруулан УИХ-д өргөн барьсан. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /2013.06.10. Е/03/;
- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /2013.09.10. Е/06/;
- Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /2013.11.21 Е/09/ зэрэг хуулийн төслүүд багтсан болно.

2011 онд өргөн мэдүүлсэн Шүүхийн тухай багц хуулийн төслүүд 2012 онд Улсын Их Хурлаар батлагдаж 2013 оны 04 дүгээр сарын 15-наас хэрэгжиж эхлэв. Мөн 2011 онд өргөн мэдүүлсэн Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг буцааж (2013.01.24) татаж авсан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн дээрх хуулийн төслүүдээс УИХ-аар Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар, өөрөөр хэлбэл яагаад хуулийн төслийг боловсруулах шаардлагатай болсон, түүний шаардлага, үндэслэлийн талаар тоймлон танилцуулъя.

Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай

Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дараах практик шаардлага, эрх зүйн үндэслэлийг харгалзан боловсруулсан болно. Үүнд нэгдүгээрт, Үндэсний хорооны үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлэх чиг үүрэг, ажлын зохион байгуулалт нь Засгийн газрын эрхлэх асуудалд хамаарч байгаа нь Засгийн газрын болон Ерөнхийлөгчийн институцийн бүрэн эрхийн зарим давхардлыг бий болгож байсан тул үүнийг зохистой шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2011 оны 02 дугаар сарын 10-нд Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн төсөл боловсруулан Улсын Их Хуралд өргөн барьж Улсын Их Хурал баталсан. Энэхүү хуулийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2011 оны 43 дугаар зарлигаараа Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах, үйл ажиллагааны харилцан уялдааг хангахад хяналт тавих үүрэг бүхий Үндэсний хороог байгуулсан.

Уг хуулийг шинэчлэн найруулж “Агаарын тухай хууль” нэртэйгээр 2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр баталсан бөгөөд энэхүү хуулиар Үндэсний хороо байгуулагдах зарчим, түүний хэрэгжүүлэх чиг үүрэгт өөрчлөлт оруулаагүй юм.

Үндэсний хороо нь Агаарын бохирдлыг бууруулах талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх үндсэн бүтэц мөн. Тус Хороо нь Агаарын тухай хуулийн 5.1.1-т зааснаар агаарын бохирдол бууруулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах, үйл ажиллагааны харилцан уялдааг хангахад хяналт тавих гэсэн үндсэн хоёр чиг үүрэгтэй.

Агаарын бохирдлыг бууруулах төрийн бодлогыг Агаарын тухай хуулийн 3.1.11 болон 6.1-т заасны дагуу “агаар хамгаалах” бүрэн эрхийн хүрээнд Засгийн газар үндэсний хөтөлбөрөөр баталдаг бөгөөд түүнийхээ хэрэгжилтийг зохион байгуулах үүрэгтэй. Энэхүү харилцаан дахь Үндэсний хорооны үндсэн чиг үүргийн оролцоо нь Засгийн газрын чиг үүргийг Засгийн газрын бус бүтэц давхар хэрэгжүүлэх байдлыг бий болгож байв.

Үндэсний хорооны салбар дундын бодлогын хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа, тэдгээрт шаардагдах хөрөнгийн тооцоо, эх үүсвэрийн асуудлыг уялдуулан зохицуулах болон хэрэгжилт, санхүүжилтэд хяналт тавих ажиллагаа нь Засгийн газрын байгууллагуудад ихэвчлэн чиглэгдэж байлаа. Үүний нэг илрэл нь Үндэсний хорооны 20 гишүүний бүрэлдэхүүнээс 65 хувь нь Засгийн газрын байгууллагуудын төлөөлөл<sup>1</sup> байгаа бөгөөд Үндэсний хорооны тогтоол, үүрэг даалгавар биелүүлэх ажиллагааг гардан гүйцэтгэх, тайлан ирүүлэх этгээд нь яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар зэрэг төрийн захиргааны байгууллагууд буюу тэдгээрт байгуулсан салбар ажлын хэсэг, хороод байгаагаас харагдаж байв.

Ийнхүү давхардсан нь төсвийн зардлыг нэмэгдүүлэх үр дагавартай байх тул цаашид ажлын уялдааг илүү сайжруулах, бүрэн эрхийн давхардлыг арилгах шаардлагын үүднээс Үндэсний хороог цаашид Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд бус Засгийн газрын бүрэн эрхэд шилжүүлэхээр тусгав.

Энэхүү бүтцийг анх бий болгохдоо цаг үеийн тулгамдсан шаардлага, ач холбогдол, анхаарал хандуулах нэн тэргүүний хэрэгцээг харгалзан Монгол Улсын Ерөнхийлөгчийн институцийн хүрээнд байгуулж байсан боловч Үндэсний хороо нь өнгөрсөн хугацаанд мэргэжлийн албан хаагчдаас бүрдсэн ажлын албыг бий болгосон, үйл ажиллагаагаа цаашид хэвийн тогтвортой үргэлжлүүлэх боломжтой болсон гэж үзсэн.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газар нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх бүрэн эрхийн хүрээнд Төрийн захиргааны төв байгууллагуудын хоорондын болон тэдгээр байгууллага, аймаг, нийслэлийн захиргааны байгууллагын харилцан ажиллагааг нийтлэг зорилтод чиглүүлэн зохицуулах үүрэгтэй. Түүнчлэн Агаарын тухай хуулийн 3.1.11 болон 6.1-т заасны дагуу агаарын бохирдол бууруулах үйл ажиллагаа нь “агаар хамгаалах” бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын үндсэн чиг үүрэгт хамаардаг. Иймд Үндэсний хороог Засгийн газарт шилжүүлэх эрх зүйн үндэслэлтэй байв.

---

<sup>1</sup>Үндэсний хорооны 20 гишүүдийн 13 нь яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллагын төлөөлөл байна.

Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээний талаар танилцуулбал:

Агаарын тухай хууль нь хүрээлэн байгаа агаарыг хамгаалах, агаар бохирдохоос урьдчилан сэргийлэх, агаар бохирдуулах бодисын хаягдлыг бууруулж хяналт тавих харилцааг зохицуулдаг.

Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг агаарын бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах, үйл ажиллагааны харилцан уялдааг хангахад хяналт тавих чиг үүрэг бүхий Үндэсний хороог байгуулах Монгол Улсын Ерөнхийлөгчийн Агаарын тухай хуульд заасан бүрэн эрхийг Засгийн газарт шилжүүлэх зорилгоор боловсруулсан.

Иймд уг хуулийн төслөөс Үндэсний хороонд холбогдох харилцааг бүхэлд нь зохицуулж байсан “Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх” гэсэн 5 дугаар зүйлийг хасч “Засгийн газрын бүрэн эрх” гэсэн 6 дугаар зүйлд Үндэсний хороог байгуулах бүрэн эрхийг 6.1.11 дэх заалтаар нэмсэн бөгөөд түүний бүрэлдэхүүн, ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхий сайд тодорхойлохоор тусгасан 6.2 дахь хэсгийг нэмж тусгасан.

Түүнчлэн Үндэсний хорооны ажлын албаны одоогийн ажиллаж байгаа зарчмыг алдагдуулахгүй байх шаардлагын үүднээс 6.3 дахь хэсгийг мөн нэмж “байнгын цахим мэдээллийн сүлжээг ажиллуулах, иргэдэд мэдээлэл тогтмол авах боломжийг хангах” үүргийг тусгасан. Ажлын албаны санхүүжилтийн хувьд өмнөх зохицуулалтыг мөн хэвээр хадгалсан бөгөөд 6.4 дэх хэсэгт улсын төсвөөс санхүүжүүлэхээр заасан.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн 2013 онд санаачлан боловсруулж Улсын Их Хуралд өргөн барьсан Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурал батлах хүртэл (2013.12.12) хугацаанд агаарын бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах, үйл ажиллагааны харилцан уялдааг хангахад хяналт тавих үүрэг бүхий Үндэсний хорооны хийсэн ажлаас танилцуулья.

- Нийслэлийн төвийн зургаан дүүрэгт Засаг дарга нараар ахлуулсан Үндэсний хорооны салбар хороодыг байгуулан ажиллуулж байна. Мөн агаарын чанарын асуудал хариуцсан гэрээт ажилтнуудыг ажиллуулж байна.
- Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Сангийн яам, Эрчим хүчний яам, Зам, тээврийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Уул уурхайн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт Агаарын бохирдлыг бууруулах ажлын хэсгүүд байгуулан ажиллуулж байна.
- Агаарын бохирдол хүлцэх дээд хэмжээнээс хэтэрсэн Архангай, Булган, Баянхонгор, Дархан-Уул, Өвөрхангай, Сүхбаатар, Хөвсгөл, Ховд аймгийн Засаг дарга нарт заавар, зөвлөгөө өгч тухайн аймаг бүрт агаарын бохирдлыг бууруулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.
- Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд багтсан зургаан дүүргийн 50 хорооны 684 хэсгийн ахлагчийг “Агаарын чанарын орон тооны бус байцаагч”-аар цалинжуулан ажиллуулж байна.

- Ахуйн хэрэглээний зуух, Хагас коксон түлш, Шахмал түлш, Ахуйн зориулалтын диметилийн эфир, Гэр болон барилга байгууламжийн дулаалгын нэгдсэн стандартуудыг боловсруулан батлуулж мөрдөж эхлээд байна.
- Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний үнийн урамшуулах олгох журам, Агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журам, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүс дэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх журам, Боловсруулсан түлш нөөцлөх, дүүрэг, хороо, иргэдэд хүргэх журам, Агаарын чанарыг сайжруулах бүс дэх түүхий нүүрсийг хязгаарлах үндсэн бүсэд орших айл өрхийг боловсруулсан түлшээр хангах нөөц бүрдүүлэхтэй холбогдуулан урьдчилгаа санхүүжилт олгох тухай журам, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүсэд хяналт тавьж ажиллах орон тооны бус байцаагчийн ажиллах журмуудыг боловсруулж батлуулан мөрдөж ажиллаж байна. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогоо явуулах журмыг шинэчлэн боловсруулж Хууль зүйн яаманд хүргүүлээд байна.
- Барилга, хот байгуулалтын яамнаас “Газар чөлөөлөх, нүүлгэн суурьшуулах тухай хууль”-ийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн.
- “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”-нд нэмэлт, өөрчлөлт оруулсан. 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон баримт бичигт тодотгол хийсэн.
- Үндэсний хорооноос санаачлан Засгийн газартай зөвшилцсөний үндсэн дээр төрөөс хөрөнгө гаргахгүйгээр боловсруулсан түлшний үйлдвэр байгуулах сонирхолтой аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн төслийг хэлэлцэж “Шивээ коал” ХХК, “Модун ресурсэс” ХХК, “Хөх чоно” групп, “Баялаг эрдэнэ цом” ХХК-тай “Түлш нийлүүлэх гэрээ” байгуулах зөвшөөрлийг өгсөн.
- Жил бүр “Агаарын чанарыг сайжруулах бүс”-ийг шинэчлэн тогтоож, бүсэд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллалаа.
- Засгийн газрын 2012 оны 191 дүгээр тогтоолоор Улаанбаатар дулааны Ү цахилгаан станцыг “Хөлийн голын хөндий”-д барихаар шийдвэрлэсэн бөгөөд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийгдэж байна. Энэхүү станцыг барьж ашиглахад шаардагдах ус хангамж, нүүрсний тээвэр, үнс зайлуулах, станцын үйлдвэрлэсэн дулаан, цахилгааны эрчим хүчийг хэрэглэгчдэд хүргэхэд шаардлагатай инженерийн барилга байгууламж, шугам сүлжээ, тэдгээрийн трасс, тус станцыг ашиглалтад оруулахад бэлэн болгох төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай:

2011 онд шинээр батлагдсан Төсвийн тухай хуулийн нэг үндсэн зорилго нь орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангахад чиглэгдсэн билээ. Орон нутгийн төсвийн шинэтгэлийн үзэл баримтлал нь Монгол Улсын Ерөнхийлөгч өөрийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртөө орон нутгийг дэмжих, хөрөнгө, санхүүгийн эрхийг тухайн орон нутагт



шилжүүлэн, иргэдийн оролцоог хангах ажлыг эхлүүлнэ гэж тусгасаны дагуу боловсруулагдсан юм.

Уг хуульд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн орон нутгийн хөгжлийн санд хөрөнгө эх үүсвэр хуваарилах шилжүүлгийг орон нутгийн хөгжлийн индекс, хүн амын тоо болон нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, мөн түүнчлэн орон нутгийн татварын идэвх санаачилга зэрэг дөрвөн үзүүлэлтээс хамаарахаар заасан болно. Үүнийг тооцох аргачлалыг Засгийн газраас батална хэмээн хуульчилсан.

Гэвч Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт болох “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-д дээрх дөрвөн итгэлцүүрийг бүгдийг 25 хувиар тооцохоор тэгшитгэсэн нь хуулийн үзэл баримтлалын гол утга санааг алдагдуулсан байв.

Тухайлбал, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд Сангийн яамны тооцоогоор 2013 онд нийт 250 тэрбум төгрөг төвлөрөх бөгөөд үүний 20 хүрэхгүй хувь нь (40 орчим тэрбум төгрөг) хүн амын хагас нь нэгэнт суурьшаад байгаа Улаанбаатар хотод хуваарилагдахаар байгаа нь гажуудал болжээ гэж дүгнэж болохоор байна. Нийслэл хотын хөгжлийн асуудлуудыг сум, аймгийн хөгжлийн асуудалтай харьцуулах боломжгүй бөгөөд Улаанбаатар хотод шийдвэрлэх дэд бүтэц, зам, дулаан, агаарын бохирдол, хот төлөвлөлт зэрэг маш олон асуудлууд байсаар байхад үүнийг үл тоомсорлож байгаа нь яав ч зөв алхам биш юм.

Үүнээс гадна Ховд, Увс аймгийн төвүүдэд 40 орчим мянга гаруй хүн тус тус амьдарч байна. Эдгээр аймгийн төвийн сумын орон нутгийн хөгжлийн санд нь 730-750 сая төгрөг хуваарилагджээ. Гэтэл 2 мянга орчим хүнтэй сумдуудад 300-400 орчим сая төгрөг хуваарилагдсан байна. Увс аймгийн Давст сум улсын хэмжээнд хамгийн том хэмжээтэйд тооцогдох Увс нуурын талбайгаар, Завхан сум Хяргас нуурын талбайгаар орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжилт авч байна гэж хэлж болохоор байна. Мөн Улаанбаатар хотын Багахангай дүүрэг 3000 орчим хүнтэй боловч газар нутаг томтой гэсэн үзүүлэлт давамгайлан 2 тэрбум орчим төгрөг авч байхад 170 орчим мянган хүнтэй Чингэлтэй дүүрэг 2.4 тэрбум төгрөг авч байх жишээтэй.

Түүнээс гадна загварчилсан шилжүүлгийн шалгуур үзүүлэлтүүд болон тэдгээрийн хувь хэмжээг аймаг, нийслэл болон сум, дүүргийн төсөвт адилхан байхаар дээрх аргачлалд тусгасан нь ч хүндрэл авчирч байна. Эдийн засгийн зарим үзүүлэлтүүд, тухайлбал, хөгжлийн индекс болон ДНБ-ийг сумын хэмжээнд тооцдог тогтолцоо одоо ч байхгүй, зарим нэг алдаг оног тооцоо байгаа нь итгэл үнэмшил төрүүлэхээр байж чадахгүй байгаа юм.

Зарлага санхүүжилтийн гол үндсэн суурь нь хүн. Шинэчлэлийн Засгийн газрын төсөв нь хүн төвтэй төсөв байх ёстой. Газар нутаг, төвөөс алслагдсан байдал нь бензин шатахуун, томиллолт гэх мэт зардалд л нөлөөлөх болохоос гол зардлын хүчин зүйл биш юм. Тэгэхээр хүн амын тооноос хамаарсан хамаарал нь 25 хувь байгааг нэмэгдүүлэн 60-70 хувь болгох байдлаар асуудлыг дахин харах хэрэгтэй байна. Энэ зарчмыг үндэс болгон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд оруулах загварчилсан шилжүүлгийн шалгуур үзүүлэлтийн хувь хэмжээг Төсвийн тухай хуулинд хатуу зааж өгөх шаардлага гарч ирж байна. Мөн аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаас сум, дүүргүүдэд

хуваарилах загварчилсан шилжүүлгийн итгэлцүүр, үзүүлэлтүүдийг ч аймаг, нийслэлийнхээс ялгавартай авч үзэн хуулиар зохицуулах шаардлага гарч байна.

Мөн 40-60 мянган хүн амтай 12-18 багтай аймгийн төвүүд, нийслэлийн дүүргүүдийн баг, хороодын хувьд тулгарч буй бэрхшээл, шаардлага хэрэгцээ ихээхэн ялгаатай байдал харагдаж байна. Тухайлбал, Ховд аймгийн Жаргалант сум гэхэд 40 гаруй мянган хүнтэй 12 багт хуваагдах ба зарим багт нь хөрсний бохирдол хэрээс хэтэрч хүүхэд багачууд, иргэдийн дунд халдварт шар өвчин ихээхэн хүндрэх байдалтай байхад, зарим байшин хорооны баг нь инженерийн шугам сүлжээ гол асуудал, харин мал аж ахуйн багуудад худгийн асуудал гм. Нөгөө талаас, төвөөс алслагдсан, хүн ам цөөн, тархуу амьдардаг зарим багуудаа бодвол хүн ам илүү нягтралтай амьдардаг, зохион байгуулалтад орох илүү боломжтой, илүү олон хүн амтай баг, хороод асуудлаа эхний ээлжинд шийдэх давуу боломжтой байгааг зохицуулах тодорхой механизм үгүйлэгдэж байгаа болно. Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг, Ховд аймгийн төв Жаргалант сум, Увс аймгийн төв Улаангом сумуудад өөр өөрсдийн баг, хороодод орон нутгийн хөгжлийн сан байгуулах санаачилга гарган хэрэгжүүлж байгаа нь энэ чиглэлээр гарч байгаа сайн туршлага болж буйг нийтийн хүртээл болгох нь зүйтэй.

Мөн Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр, санхүү төсвийн боломжийг цаашид аажмаар нэмэгдүүлэх нь зүйтэй.

Төсвийн тэнцлийн ашиг буюу зарлагаас давсан орлого нь Орон нутгийн хөгжлийн санд орж эх үүсвэр нь болохоор хуулинд заасан нь орон нутгийн төсвийн шинэтгэлийн үзэл баримтлалд бүрэн нийцэж байгаа билээ. Гэтэл Төсвийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийн үеэр 56.2 зүйлд “Доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашгаас суурь зарлагатай тэнцэх хэсгийг тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ” гэж заасан нэмэлт оруулсан нь дээрх заалттай зөрчилдөж улмаар Төсвийн тухай хуулийн үзэл баримтлалд харшилж байгааг засаж залруулах шаардлага гарч байна.

Харин одоогийн Төсвийн тухай хуулинд байгаа орон нутгийн хөгжлийн индекс гэсэн үзүүлэлтийг орон нутгийн загварчилсан шилжүүлгийн шалгуур үзүүлэлт биш харин Улсын төсөв болон аймаг, нийслэлийн төсвөөс сум, дүүрэгт шууд хөрөнгө оруулалт хийхэд ажлын зориулалтаар ашиглаж болох үзүүлэлт гэж үзэх нь зүйтэй гэсэн эдгээр үзэл санааг баримтлан Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ нь Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутагт хөрөнгө, эх үүсвэрийг хуваарилах шалгуур үзүүлэлтүүдийг илүү тодорхой болгох, хувь хэмжээг хуулиар хатуу заан өгч хууль эрх зүйн орчинг илүү тогтвортой, удаан хугацаанд мөрдөх боломж, нөхцөлийг бүрдүүлэх зорилготой. Мөн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө эх үүсвэрийг аажмаар нэмэгдүүлэх, үүнээс гадна Төсвийн тухай хуулинд буй зарим зөрчилтэй заалтыг зохицуулах зорилгыг агуулсан.

Уг хуулийн төсөл нь орон нутгийн төсвийн харилцааг зохицуулсан зүйл, хэсэг, заалтыг агуулсан 5 зүйлтэй болно.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай:

Монгол Улсын Үндсэн хууль нь тус улсын нийгэм, эдийн засаг, төрийн байгууллын тулгуур үндэс, хүний эрх, эрх чөлөө, төрийн болон орон нутгийн эрх барих байгууллагуудын тогтолцооны үндсэн эхийг баталгаажуулсан улс төр, эрх зүйн тулгуур баримт бичиг болохын хувьд урт хугацаанд, тогтвортой үйлчлэх учиртай. Гэсэн хэдий ч энэхүү үзэл санаа нь улс орны хөгжил, цэцэглэлт, нийгэм, эдийн засгийн амьдралд гарч буй өөрчлөлт, шинэчлэлтийн тушаа болох учиргүй.

Энэ үндэслэлээр 1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд 2000 онд Улсын Их Хурал нэмэлт, өөрчлөлт оруулсан нь төрийн ажилд бэрхшээл учруулаад зогсохгүй өнөөг хүртэл шүүмжлэл, маргаан дагалдуулж ирсэн нь Үндсэн хуульд оруулсан тэдгээр нэмэлт, өөрчлөлтийг дахин хянаж нягтлан үзэх шаардлагатайг илтгэн харуулж байна.

Тодруулбал, Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүнээр давхар ажиллах боломж олгосон Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй” гэсэн зохицуулалт нь төрийн хууль тогтоох дээд байгууллага Улсын Их Хурал болон түүний баталсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, гүйцэтгэх үүрэг бүхий Засгийн газар хоорондын зүй зохист харилцаа, эрх мэдэл, чиг үүргийн хуваарилалт, хяналтын тогтолцоог алдагдуулах гол үндэс болж байгаа тул энэ зохицуулалтыг эргэн харах шаардлагатай байна.

Энэ асуудлыг шийдвэрлэх зорилгоор Улсын Их Хурлын зарим гишүүдээс Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэд хэдэн хуулийн төслийг тус тусдаа боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсний дагуу Улсын Их Хурлын даргын 2011 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 05 тоот захирамжаар “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг судлах үүрэг бүхий Ажлын хэсэг”-г Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар ахлуулан байгуулан, ажиллаж байна.

Гэвч энэхүү ажлын хэсгийн боловсруулсан хуулийн төсөл нь тус улсад үүсээд буй төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналтын тогтолцоо алдагдсан өнөөгийн байдлыг бүрэн засаж, залруулж чадахгүй, аргацаасан шинжтэй зохицуулалт санал болгож байгаа тул Монгол Улсын Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалд нийцүүлэн, төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналтын талаарх эрх зүйн зохицуулалтыг тодотгон сайжруулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах шаардлага тулгарсан юм.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тухайн харилцааг илүү нарийвчлан зохицуулж буй “органик” хуулиудад өөрчлөлт оруулах замаар тодорхойлон, тайлбарлах зорилго бүхий 2 зүйлтэй.

1. Улсын Их Хурлаас 2000 онд Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй” гэсэн өөрчлөлтийг даган Монгол Улсын Засгийн газрын тухай

хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийг “Ерөнхий сайдаас бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй” гэсэн байдлаар өөрчилж, илүү нарийвчилсан зохицуулалтыг “органик” хуулийн төвшинд хийнэ.

Ингэснээр Үндсэн хуулийн зүйл заалтыг хөндөхгүйгээр “органик” хуульд шууд зааж өгөх байдлаар Үндсэн хууль дах төрийн эрх мэдэл хуваарилах суурь үзэл баримтлалыг сахин хамгаалж, улмаар Засгийн газрын бүрэлдэхүүнийг бүхэлд нь Улсын Их Хурлын гишүүд хавсран ажиллах боломжийг олгож буй хууль, эрх зүйн орчинг хязгаарлах болно.

## 2. Энэхүү хуулийг дагаж мөрдөх хугацааг тусгай заалтаар тогтооно.

Ийнхүү Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулснаар парламентат ёсыг боловсронгуй болгож бэхжүүлэх, төрийн эрх мэдэл хоорондын хяналт, хариуцлагын зохистой тогтолцоог сэргээн тогтоож Үндсэн хуулийн үзэл санааг хадгалж үлдэх боломжтой гэж үзсэн билээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2013 оны 06 дугаар сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлах саналыг Улсын Их Хурлын 2014 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжээгүй тул Улсын Их Хурлын 2014 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн “Хуулийн төслүүдийг буцаах тухай” 33 дугаар тогтоолоор хууль санаачлагчид буцаасан болно.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2013 онд: Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт “Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаар бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавина” гэж заасныг үндэслэн дараах хуулийн төсөлд хориг тавьсан.

Монгол Улсын Их Хурлаас 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд “Үндэсний их баяр наадмын тухай хуулийг олон улсын жишиг, өнөөгийн хөгжлийн чиг хандлагыг харгалзан нийт ард иргэдээр нээлттэй хэлэлцүүлж, мэргэжлийн байгууллагуудын саналыг авч, өргөн хүрээнд шинэчлэн найруулах нь зүйтэй гэж үзэж байна” гэсэн үндэслэлээр бүхэлд нь хориг тавьсан.

Улсын Их Хурал 2013 оны 07 дугаар сарын 09-ний өдөр “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” 50 дугаар тогтоол гаргаж “2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн зөвшөөрсүгэй” хэмээн хоригийг хүлээн авсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 16-д заасан “Бүх шатны шүүгчийг хуульд заасны дагуу томилно”, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор, хяналтын шатны шүүхийн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөл санал болгож Улсын Их Хуралд

танилцуулснаар тус тус Ерөнхийлөгч томилно” гэж заасны дагуу шүүгчдийг томилох болон бусад асуудлыг судлан шийдвэрлэлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүнээр Пүрэв овогтой Оюунчимэгийг томилуулах саналыг 2013 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн Е/01 дугаар албан бичгээр Улсын Их Хурлын дарга З.Энхболдод хүргүүлсэн. Улсын Их Хурлын 2014 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Хүний эрхийн үндэсний комиссын гишүүдийг томилох тухай” 14 дүгээр тогтоолоор П.Оюунчимэгийг Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээр томиллоо.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 17 дахь хэсэг, Прокурорын байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын дарга З.Энхболдод 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Е/25 дугаар албан бичгээр Улсын Ерөнхий Прокурорын орлогчоор Ганбатын Эрдэнэбатыг томилох тухай саналыг зөвшилцөхөөр хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 03 дугаар зарлигаар Г.Эрдэнэбатыг Улсын Ерөнхий Прокурорын орлогчоор томилсон. Мөн 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн Зэрэг дэв олгох тухай 21 дүгээр зарлигаар Улсын Ерөнхий Прокурорын орлогч Г.Эрдэнэбатад Төрийн хууль цаазын шадар зөвлөхийн зэрэг дэв олголоо.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2013 оны 08 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлын дарга З.Энхболд, Ерөнхий сайд Н.Алтанхуяг нарыг хүлээн авч уулзаж Монгол Улсын эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын нөхцөл байдлын талаар ярилцаад Монгол Улсын Засгийн газар, Монголбанк, төрийн байгууллагууд үүссэн нөхцөл байдлыг дор бүрдээ үнэлж эрчимтэй ажиллах нь зүйтэй, шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудлуудыг шийдвэрлүүлэх чиглэлээр Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулж болох юм гэсэн байна.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2013 оны 08 дугаар сарын 15-ны өдөр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн үе үеийн гишүүдийн төлөөлөлтэй уулзаж Монгол Улсын эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын асуудлаар санал солилцсон байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Засгийн газрын хуралдаанд өөрийн тааллаар оролцож, санал бодлоо илэрхийлэх бүрэн эрхийн хүрээнд 2013 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд оролцож Засгийн газраас агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хийсэн ажлын талаар мэдээлэл сонсоод,

- Хоёрдугаар цахилгаан станц дээр хагас коксжсон нүүрс гаргах ажил яг юунаас болоод зогссон тухай;
- Тавдугаар цахилгаан станцын асуудал шийдэгдсэн үү, энэ хавар баригдаж эхлэх үү?;
- Хөрсний бохирдол гээд ноцтой асуудал хөндөгдөөд байна. Ийм үед ундны цэвэр усны асуудлыг хэрхэн шийдэх вэ?, Энэ асуудлаас болоод гэр хорооллын барилгажилт зогсчихвол яах вэ?, Улаанбаатарын гэр хорооллын барилгын усны асуудлыг ямар эх үүсвэрээр шийдэх вэ?, Бохирдсон хөрсийг яах гэж байна?, Цэвэрлэх байгууламжийн асуудал ямар байна, төсөл хөтөлбөрүүд хэрэгжээд байдал хэр өөрчлөгдсөн бэ?;

- Барилгын шинэ стандартууд хэзээ батлагдах вэ?;
- Жил тутам Улаанбаатарыг тойрсон газар хөдлөлт хоёр дахин нэмэгдээд байна. Долоон баллаар хөдлөхөд барилга байгууламжийн 70 хувь нь нурахаар байгаа. Үүнээс айх биш бэлтгэлтэй байа гэсэн. Одоо та нар яг юу хийж байна?;
- Богд уулын урдуур тавигдах төмөр зам юу болсон бэ?, техник эдийн засгийн үндэслэлийг нь хэдийнэ гаргасан байсан. Гэтэл энэ ажил чухам ямар учраас зогсчихоод байна вэ?, энэ төмөр замын барилгын ажил хэзээ эхлэх вэ?, энэ төмөр зам хотын төвлөрлийг сааруулахад зайлшгүй шаардагдах дэд бүтцийн амин чухал хэсэг нь юм. Энэ ажлыг хэн хариуцаж байна вэ?;
- Оюутны хотхоныг өмнөх Засгийн газар удтал ярьсны эцэст Багануурын чиглэлд байгуулахаар тогтсон. Хотын төвлөрөл, хөдөлгөөний ачааллыг бууруулахад энэ нь маш том түлхэц болох учраас уг ажлыг орхигдуулах ёсгүй гэж ярилцсан. Энэ ажил ямар шатандаа явна вэ? гэсэн асуултыг Засгийн газрын гишүүдээс асууж тэдний хариултыг сонсож ярилцаад саналаа хэлсэн билээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж энэ өдрийн Засгийн газрын хуралдааны ач холбогдлыг “Утаа гэж бид төлөөлүүлэн ярьдаг болохоос үүний цаана хөрсний бохирдол, газар доорх инженерийн шугам сүлжээ гээд олон хурцадсан асуудал бий. Түүнчлэн цаашид хот, хөдөөгийн хөгжлөө хэрхэн уялдуулах гээд том асуудлууд биднийг хүлээж байна. Анхаарал татсан асуудлаар Засгийн газрын гишүүд, Улаанбаатарын удирдлага хамт сууж, асуудлаа нийтээрээ шийдээд хүч нөөцөө төвлөрүүлж, гаргасан шийдвэрээ үр дүн гартал нь хэрэгжүүлэх боломжтой. Ингэж хамтарч хэлэлцэх нь өнөөдрийн хуралдааны ач холбогдол юм” гэж дүгнээд хэд хоногийн өмнө Улсын Их Хуралд асуудлыг хэрхэн шийдэх талаар хэлэлцэж хаалттай хуралдсан. Харин өнөөдөр Засгийн газрын нээлттэй хуралдаан болж байна. Улсын Их Хурлын чуулганаар бид ерөнхий механизм, аргачлалаа тогтоож ярилцсан. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын гишүүд хамтран зарим чухал асуудлаа ярилцаад шийдэл нь шаардлагатай, боломжтой бол Засгийн газрын төвшинд шийдвэрлэх механизмд шилжиж байна гэж би хувьдаа үзэж байна гэсэн юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хуралдааны төгсгөлд Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдэд хандан:

... Асуудал явж явж энэ эрх мэдэл, эд мөнгөний төвлөрлийн асуудал болчихоод байгаа юм. Эрх мэдлийн төвлөрлийг сааруулах, эд мөнгөний төвлөрлийг сааруулах том асуудлаа барьж явъя. Энэ Улаанбаатарын асуудал ийм том олон зүйлтэй холбоотой болоод байна. Том асуудлыг голоос нь барьж авдаг юм. Том асуудлыг тойрч явдаггүй юм. Бүх анхаарлаа, хүчээ түүнд чиглүүл, бүх хөрөнгөө түүнд оруул, шийдвэр гаргах тэр эрх мэдлээ түүнд ашигла, цагаа төвлөрүүлээд ажилла гэж хэлэх гээд байгаа юм.

Гэтэл одоо манай Засгийн газар дээр яриад байгаа юм жижиг байна. Ер нь манай дарга нар нэг зүйлд анхаармаар байна. Хүний эрхийг засварлах эрх ямар ч дарга нарт байхгүй шүү. Дарга болохоос чинь өмнө хүний эрх байсан юм. Хүн өмчөө эзэмших, үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй. Бидэнд, Засгийн газарт хүний эрхэд халдах эрх, үүрэг байхгүй.

Гол асуудал руугаа ор. Асуудлаа голоос нь барьж аваад барьцаа ахиулаад л шийд. Засгийн газар дээр нэг хэлэлцдэг, нэг сонсдог тэгээд л орхичихоод байна. Бүр гүйцэтгэлээр нь хармаар байгаа юм. Би үүнийг л өнөөдөр хэлэх гэсэн юм. Бүрэн

эрхийн хугацаа, асуудал шийдэх хугацаа бол их богинохон шүү. Асуудлынхаа шийдлийг гаргаад Засгийн газрын хуралдаан дээр гурван удаа яриад гүйцэтгэлтэй нь, хяналттай нь авч хэлэлцээд явах нь ач холбогдол ихтэй. Ингэх юм бол ард түмэн баярлана. Бид чинь асуудал шийдэх гэж гарч ирсэн гэдгээ мартаж болохгүй гэж дүгнэн хэлсэн.

Монгол Улсын Засгийн газраас дээрх хэлэлцсэн асуудалтай холбогдуулан 2013 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр зургаан заалт бүхий “Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 18 дугаар тогтоолыг гаргасан юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Засгийн газрын Шадар сайд Д.Тэрбишдагва, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга, дэд сайд Ц.Туваан, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Т.Дуламдорж нарыг 2013 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр хүлээн авч уулзан өвөлжилтийн байдал, цас, зудын асуудлаар мэдээлэл сонслоо. Шадар сайд Д.Тэрбишдагва, 18 аймгийн 91 суманд өвөлжилт хүндэрсэн, ялангуяа Өвөрхангай, Хөвсгөл, Завхан, Архангай, Баянхонгор аймагт байдал илүү хүнд байгаа, нутгийн нь 70-аас илүү хувь нь цасан бүрхүүлтэй, тэр нь хунгарлалгүй хатуурсан, мөн өвөлжилт хүндэрсний улмаас улсын хэмжээнд өнгөрсөн жилийн эцсээр тоолуулсан 40,4 сая толгой малаас 32700 нь буюу нийт мал сүргийн 0,8 хувь нь хорогдоод байгаа тухай танилцууллаа.

Мэдээллийг сонссоны дараа Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж зудын үед хэрхэн ажиллах талаар байнгын бэлэн төлөвлөгөөтэй болох, тусламжийг малчны хотонд хүргэх, зудын үр дагаврыг арилгах, малгүй болсон айл өрхүүдээ яаж дэмжих бодлого, төлөвлөгөө нь хүмүүст ойлгомжтой, бэлэн байх ёстой гэсэн юм. Ингээд малчин түмэндээ туслах ажил өрнүүлэх нь зүйтэй гэж үзээд нийт иргэдэд хандан “Хүн бүр, аж ахуйн нэгж бүр, байгууллага бүр малчиддаа туслах үйл ажиллагааг өрнүүлцгээе!” хэмээн уриалга гаргасныг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд дэмжиж малчдад дэмжлэг тусламж үзүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2013 онд Засгийн газарт чиглэл өгсөн 5 зарлиг, иргэд олон нийт, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн удирдлагад хандсан 1, нийт 6 зарлиг гаргасан. Үүнд:

1. Засгийн газарт чиглэл өгөх тухай (2013.03.29, 42). /Цаа буга маллан тайгад амьдарч буй уйгар угсааны тува хүмүүсийн амьдралын төвшинг дээшлүүлэх, .../;
2. Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах тухай (2013.05.20, 78);
3. Засгийн газарт чиглэл өгөх тухай (2013.06.10, 88). /... “шилэн данс”-ны тогтолцоонд шилжих.../;
4. Засгийн газарт чиглэл өгөх тухай (2013.06.28, 92). /... 18-25 насны, хугацаат цэргийн алба хаагаагүй тус улсын иргэн эрэгтэйчүүдийг .../;
5. Засгийн газарт чиглэл өгөх тухай (2013.11.25, 178). /... Улаанбаатар хотын ундны эх үүсвэрийг хамгаалах, хот, суурин газрын иргэдийн амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх .../;
6. “Их Майдар цогцолборын тухай” (2013.02.08, 27).

Эдгээр зарлигийн агуулгыг дэлгэрэнгүй танилцуулбал:

1. Засгийн газарт чиглэл өгөх тухай (2013.03.29. 42). Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын нутагт оршин сууж, цаа буга маллан тайгад амьдарч буй уйгар угсааны тува хүмүүсийн /цаашид “Цаатан иргэн” гэх/ амьдралын төвшинг дээшлүүлэх, тэдний боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг сайжруулах, цаа бугын аж ахуйг сэргээх зорилгоор батлагдсан “Цаа бугын аж ахуйг сэргээх, цаачдын амьдралын төвшинг сайжруулах” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Засгийн газарт чиглэл өгсөн.

Дээрх зарлигийг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Засгийн газраас “Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 168 дугаар тогтоолыг гаргаж, тус зарлигийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна.

2. Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах тухай (2013.05.20. 78). Монгол Улсын иргэдийн Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах шалгуур нөхцөлийг дараах байдлаар тогтоож хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосон. Үүнд:

1. Дэлхийн шилдэг их сургуулийн зэрэглэлийн эхний 20-д багтсан сургуульд суралцагчид хүсэлтийг нь үндэслэн суралцаж буй мэргэжлийн чиглэлийг харгалзахгүйгээр санхүүжилт олгох;

2. Дэлхийн шилдэг их сургуулийн зэрэглэлийн 21-100-д багтсан сургуульд суралцагчид Монгол Улсын Засгийн газраас зарласан мэргэжлийн чиглэлийг харгалзан хүсэлтийг нь үндэслэн санхүүжилт олгох;

3. Монгол Улсын Засгийн газар дэлхийн шилдэг их сургуулиудад суралцуулах мэргэжлийн чиглэлийг өмнөх оны эхний хагас жилд, суралцуулах хүний тоог тухайн оны 2 дугаар сард багтаан өөрийн цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;

4. Монгол Улсын иргэдийг Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр дэлхийн шилдэг их сургуульд суралцуулахад шаардагдах зардлыг улсын төсөвт жил бүр тусгаж байх;

5. Дэлхийн шилдэг их сургуулийн зэрэглэлийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын тогтоосон зэрэглэлээр тооцох.

Монгол Улсын Засгийн газраас Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль, Боловсролын тухай хуулиудын холбогдох заалтуудыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 78 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор “Журам шинэчлэн батлах, журамд өөрчлөлт оруулах тухай 2013 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 271 дүгээр тогтоолоор “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журмыг батлан хэрэгжүүлж байна.

3. Засгийн газарт чиглэл өгөх тухай (2013.06.10. 88). Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болох “хууль дээдлэх”, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.2-т заасан төрийн албаны “ил тод байх”, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т заасан “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх” болон Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт заасан “төсвийн ил тод байдлыг хангасан байх”



зарчмыг баталгаажуулж, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгосон. Үүнд:

1. Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжигч төрийн байгууллага, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төсвийн орлого, зарцуулалт болон тайлагналын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх “шилэн данс”-ны тогтолцоонд шилжих;

2. Төсвийн гүйцэтгэл, зарцуулалтад тавих иргэний хяналтын тогтолцоо хийгээд өнөөгийн эрх зүйн орчны талаар олон нийтэд сурталчлах, иргэдийн санал дүгнэлтийг хүлээн авсан эсэхийг эргэж мэдэгдэж байх тогтолцоог нэвтрүүлэх.

Мөн энэхүү зарлигийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналтыг тавьж, идэвх санаачлагатай оролцохыг нийт иргэд, иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, хэвлэл, мэдээллийн байгууллагад хандан уриалсан.

4. Засгийн газарт чиглэл өгөх тухай (2013.06.28. 92). Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасан Монгол Улсын иргэний журамт үүрэг болох “Эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах” заалтыг хэрэгжүүлж, Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан “иргэдэд эх орноо батлан хамгаалах бэлтгэл эзэмшүүлэх” үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгосон. Үүнд:

1. Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй 18-25 насны, хугацаат цэргийн алба хаагаагүй тус улсын иргэн эрэгтэйчүүдийг оршин суугаа нутаг дэвсгэр, суралцаж буй мэргэжлээс үл хамааран сургалтын чөлөөт цагт нь цэргийн жинхэнэ албыг хаалгахтай холбогдсон эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох хуулийн төслийг санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

Монгол Улсын Засгийн газраас 2013 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн “Хөтөлбөр батлах тухай” 40 дүгээр тогтоолоор “Оюутан-цэрэг хөтөлбөр”, тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг зохион байгуулж байна.

5. Засгийн газарт чиглэл өгөх тухай (2013.11.25. 178). Улаанбаатар хотын ундны усны эх үүсвэрийг хамгаалах, хот, суурин газрын иргэдийн амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгосон. Үүнд:

1. Нийслэл Улаанбаатар хотод Үндэсний цэцэрлэгт хүрээлэнг, хот, тосгон, аймаг, сумдын төвд цэцэрлэгт хүрээлэн байгуулах, тэдгээрийг сэргээн засварлаж тохижуулахыг;

2. Үндэсний цэцэрлэгт хүрээлэн болон бусад цэцэрлэгт хүрээлэн байгуулахтай холбогдуулан эрх зүйн орчныг бүрдүүлж, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулахыг тус тус чиглэл болгосон.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч, Хүн ардынхаа үндэсний ухамсар, гүн ухааны үзэл санааг төлөвшүүлэх зорилгоор “Их Майдар сан” төрийн бус байгууллага, иргэд,

уран бүтээлчдээс гаргаж буй саналыг дэмжиж Эв нэгдэл, энэрэл нигүүслийн ёсыг эрхэмлэгч Их Майдар бурханы цогцолбор төслийг үндэсний хэмжээний бүтээн байгуулалт болгосугай хэмээн 2013 онд “Их Майдар цогцолборын тухай” (2013.02.08. 27) зарлиг гаргаж Төр улс, түмэн олныхоо цог золбоог бататгах, монголчуудын уламжлалт ёс заншил, гүн ухааныг хөгжүүлэх Их Майдар цогцолборын бүтээн байгуулалтыг дэмжиж оролцохыг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, иргэн бүрт уриалсан.

Энэхүү уриалгыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд дэмжин оролцож байгаа бөгөөд бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна.

“Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх шууд ардчилал, иргэдийн оролцоогоор дамжуулан төвлөрлийг сааруулах Бодлогын зөвлөлийн ажиллах журам” батлах тухай (2013.01.02. 1) зарлигаар 2013 оныг Монгол Улсад шууд ардчилал, иргэдийн оролцооны жил болгон зарласан.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачилгаар “Иргэдийн оролцоотой төсвийн менежмент” үндэсний хэмжээний томоохон сургалтыг Төрийн ордонд хоёр удаа (2012.09.08, 2013.02.25) зохион байгуулж, Монгол Улсын бүх аймаг, сум, нийслэлийн дүүрэг, хороодын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга нар болон иргэд олон нийтийг төлөөлсөн 3000 сургагч багш бэлтгэлээ. Уг сургалтын арга хэмжээнд Улсын Их Хурлын дарга, гишүүд, Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нар оролцлоо.

Дээр өгүүлсэн “Иргэдийн оролцоотой төсвийн менежмент” үндэсний сургалтыг тухайн орон нутагт амьдарч буй иргэдийн амьдралыг хэрхэн авч явах, ямар дэг журамтай байхыг иргэд өөрсдөө мэддэг, шийддэг ийм байгууллага, тогтолцоог бүрдүүлэх; төсвийг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцооны эрх зүйн стандартуудыг тогтоох; төвлөрлийг сааруулах, орон нутаг, иргэдэд эрх мэдэл олгох, иргэдийн оролцоог байнгын болгож, хангах чиглэлээр иргэдэд боловсрол олгох зорилгын хүрээнд зохион байгуулсан бөгөөд сургалтаар,

- “Иргэдийн оролцоотойгоор Төсвийн хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах нь”;
- “Төвлөрлийг сааруулахад иргэдийн оролцоог дэмжих үндэсний дунд ба урт хугацааны стратегийн бодлогын баримт бичиг”-ийн тухай танилцуулга;
- “Иргэний танхимаар дамжуулан оролцоог хангах нь”;
- “Хорооны дүрэм”-ийн төслийн танилцуулга;
- “Орон нутгийн иргэдийн санал хураалтын”-ийн төслийн тухай танилцуулга;
- “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн тухай төслийн танилцуулга;
- “Хорооны Иргэдийн нийтийн хурлын дэг”-ийн тухай төслийн танилцуулга;
- “Нийтийн зар мэдээг түгээх журам”-ын тухай төслийн танилцуулга;
- “Орон нутгийн эрх мэдэл, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох нь” сэдвээр тус тус сургалт явуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгч дээр дурдсан хуулийн болон зарлигийн төслүүдийг боловсруулахдаа тухайн чиглэл хариуцсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх,

эрдэмтэд, судлаачид, тухайн салбарын төрийн болон төрийн бус байгууллагын мэргэжилтнүүд, тэдний төлөөллийг багтаасан бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан ажиллалаа. Боловсруулсан төслийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимаар олон удаа нээлттэй хэлэлцүүлж олон нийтийн санаа бодлыг сонсож, тэдний саналыг төсөлд тусган төслийг боловсруулах ажлын явцыг тогтмолжуулж ажиллаж байгаа ба энэ нь "...Ард түмэн төрийн үйл хэрэгт оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан эрхээ эдэлнэ" гэсэн иргэдэд Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэх тогтолцоог олгосон, иргэний оролцоог нэмэгдүүлсэн, тухайн гарах гэж буй хууль, зарлиг шийдвэрийн талаар иргэд, олон нийтэд мэдээлэл өгсөн ихээхэн ач холбогдолтой үйл ажиллагаа болохыг энэ хугацаанд төрийн бүх шатны байгууллага аливаа нээлттэй хэлэлцүүлгийг хийж, мэдээллийг ил тод болгох ажиллагаанд ихээхэн ахиц гаргаад байгааг тэмдэглэх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл аливаа асуудлаар хэлэлцүүлэг хийх нь иргэдэд мэдээлэл өгч тэдний санаа бодлыг шийдвэрт тусгах ажиллагаа нь бүх шатны төрийн байгууллагын үүрэг боллоо.

## **ХОЁР. ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, УЛСЫГ БАТЛАН ХАМГААЛАХ ТАЛААРХИ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХИЙН ХҮРЭЭНД**

Монгол Улсын Ерөнхийлөгч Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн Тэргүүний хувьд

Монгол Улсын Ерөнхийлөгч Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийг тэргүүлж, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон бусад хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болохуйц улс төр, эдийн засаг, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн шийдвэрт хяналт тавих, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, төрийн гадаад, дотоод бодлогын нэгдмэл байдлыг хангах чиглэлээр ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн Тэргүүний хувьд Зөвлөлийн гурван удаагийн хуралдаанаар таван асуудал хэлэлцэн Зөвлөлийн зөвлөмж гурвыг гаргасан бол Зөвлөлийн Тэргүүн, гишүүд 47 асуудлыг ажлын журмаар шийдвэрлэж, Зөвлөлийн зөвлөмж, хуралдааны тэмдэглэл гаргалаа.

Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн болон Тэргүүн, гишүүд ажлын журмаар танилцаж шийдвэрлэсэн асуудлуудыг 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хурлын 48 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал" дахь аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсгүүдтэй уялдуулан авч үзвэл:

Оршин тогтнохуйн аюулгүй байдлын хүрээнд "Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах тухай", "Төрөлхийн гажиг, удамшлын эмгэгийн талаар авах зарим арга хэмжээний тухай", "Зөвлөлийн Тэргүүн, гишүүдийн олон улсын арга хэмжээ, бусад улсад хийх дээд хэмжээний айлчлал болон гадаад улсуудын төрийн өндөр хэмжээний зочдын айлчлалын үед баримтлах бодлого,

чиглэл, үр дүн” зэрэг асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэв. Шийдвэрлэгдсэн асуудлууд нь Монгол Улсын тусгаар тогтнол, харилцан итгэлцлийг бэхжүүлэх, дэлхийн хийгээд бүс нутгийн орнуудтай аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлэх, олон улсын энхийг дэмжих үйл ажиллагаанд идэвхтэй оролцон дэмжихэд ихээхэн ач холбогдолтой байж Монгол төрийн бодлогын суурь үндэслэл болсон төдийгүй гадаадад Монгол Улсын нэр хүнд, үүрэг хариуцлагыг дээшлүүлж байна.

Эдийн засгийн аюулгүй байдлын хүрээнд “Улаанбаатар метро” төсөл хэрэгжүүлэх тухай асуудал хэлэлцүүлж шийдвэрлүүлэв. Ингэснээр дэд бүтцийн салбарын хөгжлийг үндэсний аюулгүй байдлын шаардлага, хэрэгцээнд нийцүүлж, хөрөнгө оруулалтад эдийн засгийн үр ашгийг шалгуур болгох, тэнцвэртэй бодлого явуулах, интеграцийн асуудлаар зөв бодлого баримталж харьцангуй биеэ даасан, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгоход ихээхэн тус дэм болно гэж үзэж байна.

Хүний аюулгүй байдлын хүрээнд “Эм вакцин, биобэлдмэлийн хангамж, нөөц, чанар, тэдгээрийн аюулгүй байдалд тавих хяналтын тухай” асуудлыг хэлэлцэн шийдвэрлэснээр Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, эм вакцин, биобэлдмэлийн үйлдвэрлэл, нөөц, чанарт тавих стандартын шаардлага, хяналт, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгоход баримтлах гол баримт бичиг гаргасан.

Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлын хүрээнд “Байгалийн нөөцийн үндэсний парк байгуулах тухай”, “Байгаль, ургамал, амьтныг хамгаалах талаар авах зарим арга хэмжээний тухай”, “Усны нөөцийг хамгаалах, хомсдолоос сэргийлэх, зохистой ашиглах бодлогын чиглэлийн тухай” асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэснээр усны үнэлэмжийг нэмэгдүүлэх, нөөцийг хамгаалах, шинэчлэн тогтоох, байгаль орчны тэнцвэрийг хадгалж, аливаа сөрөг үр дагаврын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах зохицуулалт хийх, хяналтыг чангатгах, оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгоход баримтлах гол баримт бичиг гаргасан.

Дотоод аюулгүй байдлын хүрээнд “Галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис илэрсэнтэй холбогдсон асуудлаар ажлын хэсэг байгуулах тухай”, “Нууц Протоколыг ил болгох тухай” зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн нь нийгэмд хууль ёс, дэг журам, сахилга, хариуцлага суларч эмх замбараагүй байдал бий болохоос сэргэмжлэх, урьдчилан сэргийлэх, хариуцлагыг өндөржүүлэхэд чухал ач холбогдолтой болов.

Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах талаар Монгол Улсын төв, орон нутгийн албан тушаалтнууд гадаадын албаны болон аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөлтэй ямар ч уялдаа зохицуулалтгүйгээр ажил төрлийн уулзалт хийн элдэв яриа хэлцэл, хэлхээ холбоо тогтоож байгаа нь төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдал, нууцыг алдагдуулж, улмаар үндэсний язгуур ашиг сонирхол, аюулгүй байдалд хор хохирол учруулах эрсдэл дагуулж байна.

Иймд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.1.1-д “Төрийн гадаад бодлого нэгдмэл байх, гадаад харилцаанд үндэсний ашиг сонирхлыг дээдлэх зарчмыг тууштай хэрэгжүүлнэ”, 3.3.3.5-д “Төв, орон нутгийн бүх төвшинд

үндэсний нийтлэг ашиг сонирхол, төрийн бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг дээдэлнэ” гэж заасныг үндэслэн төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах зорилгоор Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Тэргүүн, гишүүд уг асуудлыг ажлын журмаар хэлэлцэн шийдвэрлэж, хэрэгжүүлж эхлээд байна.

Эм вакцин, биобэлдмэлийн хангамж, нөөц, чанар тэдгээрийн аюулгүй байдалд тавих хяналтын талаар Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг бүртгэх, үйлдвэрлэх, нийлүүлэх, зөвшөөрөл олгох, сурталчлах, борлуулах зэрэг эм зүйн бүх үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, эмийн гаж нөлөөнд хяналт тавих, бүсийн төвүүд болон хилийн боомтуудад эм, биобэлдмэлийн лаборатори байгуулах, шинжилгээний түргэвчилсэн аргуудыг нэвтрүүлэх, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг сүлжээгээр борлуулж байгааг зогсоох эрх зүйн орчин бүрдүүлэх, эрүүл мэндийн ажилтнуудыг сурталчилгаа, борлуулалтад оролцохыг хориглох, үндэсний эм, вакцин, биобэлдмэлийн үйлдвэрлэлийг дэмжиж Эрүүл мэндийн яаманд үйлдвэрлэл хариуцсан нэгж бий болгох зорилгоор уг асуудалтай зөвлөлийн Тэргүүн, гишүүд ажлын журмаар танилцан шийдвэрлэв.

Байгалийн ургамал, амьтныг хамгаалах талаар авах зарим арга хэмжээний тухай Бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, хариуцлага хүлээлгэх чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэх; биологийн олон янз байдлыг хамгаалах үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлан хэрэгжүүлэх; амьтан, ургамал, бичил биетний зүйлийн олон янз байдал, популяцийн төлөв байдалд дэвшилтэт арга технологиор хяналт-шинжилгээ хийх улсын сүлжээ байгуулж ажиллуулах; байгалийн ургамлыг эмийн түүхий эдийн зориулалтаар бэлтгэж экспортлохыг хязгаарлах; онцгой ач холбогдол бүхий эмийн ургамлыг тариалах шинэ технологи, агротехникийн дэвшилтэт аргаар боловсруулах санаачлагыг дэмжсэн эрх зүйн орчин, эдийн засгийн хөшүүрэг бий болгох; бэлчээрийн даацыг байгалийн бүс бүрээр шинэчлэн тогтоох, түүнчлэн байгалийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах бодлогын шийдвэрийг шинжлэх ухааны үндэслэлтэй, тооцоо судалгаанд суурилан оновчтой гаргах үүднээс бодлогын болон технологийн судалгааны төвийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгуулж ажиллуулах асуудалтай зөвлөлийн Тэргүүн, гишүүд ажлын журмаар танилцан, шийдвэр гарган хэрэгжүүлж байна.

Байгалийн нөөцийн үндэсний парк байгуулах тухай Ирээдүйд учирч болзошгүй томоохон хэмжээний байгалийн ноцтой гамшиг тохиох, хэт дулаарал, цөлжилтөд түрэгдэн үржил шимтэй газар нутаг хомсдох, гэнэтийн бусад бэрхшээл учрах зэрэг онцгой нөхцөл бүрдсэн үед Хангай, Хэнтийн нурууд, Хөвсгөл нуурын сав газар түүний орчмын бүс нутагт ус, байгалийн бусад баялгийг ашиглах, хүн амыг шилжүүлэн байршуулах зорилгоор “Байгалийн нөөцийн үндэсний парк байгуулах” төслийн үндэслэлийг боловсруулан Зөвлөлийн Тэргүүн, гишүүдэд танилцуулсныг ажлын журмаар шийдвэрлэн 2013 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Зөвлөмж гаргасан. Гаргасан шийдвэрийг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюунд албан ёсоор хүлээлгэн өгсөн.

“Улаанбаатар метро” төслийн тухай Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас Японы хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд боловсруулсан “Улаанбаатар метро” төсөл хэрэгжүүлэх судалгааны эцсийн тайлан, метро барих асуудлыг дэмжсэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 8/33

дугаар тогтоолыг Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлөөр хэлэлцүүлэн, “Улаанбаатар метро төсөл хэрэгжүүлэх тухай” зөвлөмж, хуралдааны тэмдэглэлийг 2013 оны 06 дугаар сарын 10-ны өдөр гаргав. Уг төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг 2014 оны эхний улиралд, зураг төслийг 2016 оны эхний улиралд бэлэн болгож, улмаар 2016-2020 онд метрог барьж ашиглалтад оруулна.

Усны нөөцийг хамгаалах, хомсдолоос сэргийлэх, зохистой ашиглах бодлогын чиглэлийн тухай Уур амьсгалын өөрчлөлт, хуурайшилт зэрэг байгалийн хүчин зүйл, хүний үйл ажиллагааны нөлөөгөөр усны нөөц, чанар өөрчлөгдөж, хомсдож байгаа учир усны бодлогын нэгдсэн удирдлага, салбар дундын зохицуулалт, усны үнэ цэнэ, ашиглалтын зохистой менежмент, хэмнэлттэй хэрэглээ, гадаргын усны сүлжээг өргөтгөх, ашиглах, усны хяналт шинжилгээ, мэдээллийн сан, хаягдал усыг цэвэрлэх дэвшилтэт технологи, дахин ашиглах асуудлыг нэн даруй шийдвэрлэх зорилгоор “Усны нөөцийг хамгаалах, хомсдолоос сэргийлэх, зохистой ашиглах бодлогын чиглэлийн тухай” төслийн үндэслэлийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанаас боловсруулан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр ирүүлсэн.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс дээрх асуудлаар 2013 оны 7 дугаар сард зөвлөмж гарган усны нөөцийг хамгаалах, хомсдолоос сэргийлэх, аюулгүй байдлыг хангах бодлогын чиглэлийг тодорхойлсон “Усны нөөцийн стратегийн зарчим” боловсруулж Засгийн газарт чиглэл өгөхийг Монгол Улсын Ерөнхийлөгчид зөвлөмж болгосон.

Чингис хааны өв, онгон, Их хаадын бунхан, онгонтой холбоотой асуудлаар төрөөс авах арга хэмжээний тухай Соёл, спорт, аялал жуулчлалын яамнаас “Чингис хааны өв онгон, их хаад тэдгээрийн ураг удмынхны бунхан олдвол “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон, “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль”-ийн холбогдох заалтын дагуу хамгаалах, мэдээлэх ажлыг хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд тусгайлан заалт оруулж өгөх шаардлагатай гэдэг үндэслэлээр боловсруулсан асуудалтай Зөвлөлийн гишүүд ажлын журмаар танилцаад Улсын Их Хуралд даалгасан нэг, Засгийн газарт даалгасан 4 зөвлөмж бүхий Зөвлөлийн зөвлөмжийг 2013 оны 10 дугаар сарын 24-ний өдөр гарган хэрэгжүүлж байна.

Газар хөдлөлтийн гамшгийн талаар Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлөөс өнгөрсөн хугацаанд хийсэн болон цаашид хийх ажлын талаар 2013 оны 03 дугаар сарын 26-нд; Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг “ЖАЙКА”-гаас 2011-2013 онд хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх чадавхийг бэхжүүлэх” төслийн явцыг 2013 оны 03 дугаар сарын 29; 04 дүгээр сарын 04-нд тус тус Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулав.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл асуудлуудтай танилцаад Улаанбаатар хот орчмын газар хөдлөлтийн голомтын төлөв байдал, тэдгээрээс нийслэлд үзүүлэх гамшгийн хор уршиг, үр дагаврын аюулын судалгаа, эрсдлийн үнэлгээ, болзошгүй гамшгийн газрын зураг, гамшигт өртөж болзошгүй барилга, дэд бүтцийн байгууламжийн үнэлгээ нь Зөвлөлөөс тавьж буй шаардлагын ерөнхий дүр зургийг илэрхийлсэн, нилээд үр дүнтэй ажил боллоо гэж үнэлсэн бол “ЖАЙКА”-ын багтай төслийг цаашид үргэлжлүүлэн, хамтарч ажиллахаар тогтов.

Түүнчлэн “Газар хөдлөлтийн гамшгаас амжиж анхааруулах систем байгуулах” төслийн гүйцэтгэгч Бүгд Найрамдах Солонгос Улсын “Кореа Телеком” компанийн

удирдлагатай уулзаж төслийн ажлыг эрчимжүүлэх, санхүүжилтийг улсын төсвөөс төлөгдөх хүртэл компанийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх талаар яриа хэлэлцээ хийж дээрх ажлын хүрээнд тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх захиалгыг 2013 оны 10 дугаар сард багтаан, ойрын 2-3 сарын хугацаанд бэлэн болгох, 2014 оны эхний хагаст багтаан үндсэн ажлыг дуусгахаар тохиролцов. Түүнчлэн газар хөдлөлтийн гамшгийг амжиж анхааруулах систем байгуулах төслийн хүрээнд телевиз, радиогоор зарлан мэдээлэх системийн туршилтын дохио дамжуулах сургууллт, төслийн хоёр дахь шатыг 2014 онд үргэлжлүүлэн гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, Дэд бүтцийн онц чухал байгууламжийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны нэгдсэн журам, стандартын тухай мэдээллийг хэлэлцлээ.

Хотыг дахин хөгжүүлэх талаар “Хотыг дахин хөгжүүлэх тухай” хуулийн төслөөс гэр хорооллын айл өрхийн газрыг албадан чөлөөлөх хэсгийг хасч, Барилга, хот байгуулалтын яамнаас боловсруулж буй “Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх тухай” хуулийн төсөлд оруулан боловсруулав. Гэвч явцын дунд үүссэн нөхцөл байдал, гарсан саналуудыг үндэслэн “Газар албадан чөлөөлөх тухай” хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгээс хуулийн нэрийг өөрчилж Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн нөхөн олговортойгоор газар чөлөөлөх тухай хуулийн төсөл боловсруулж байна. Хуулийн төслийн хүрээнд Газар чөлөөлөлтийн нөхөн олговрын үнэлгээний журам, Газар чөлөөлөх, суурьшуулах төлөвлөгөө боловсруулах журам, Газар чөлөөлөх зорилгоор урьдчилсан судалгаа хийх журам, Газар чөлөөлөлтийн нөхөн олговрын үнэлгээний мэргэшүүлэх сургалт явуулах, үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэх журмын төслийг боловсруулж байна.

“Хотыг дахин хөгжүүлэх тухай” хуулийн төслийг Засгийн газрын 2013 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж 2013 оны 12 дугаар сарын 05-нд УИХ-д өргөн бариад байна.

Монгол Улсын төрөөс төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай “Монгол Улсын төмөр замын талаар төрөөс баримтлах бодлого”-ын хэрэгжилтийн явцын талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргатай 2013 оны 05 дугаар сарын 10-нд уулзаж мэдээлэл сонсон, ажлыг эрчимжүүлэхийг үүрэг болгов.

Төмөр замын суурь бүтцийг төрийн өмчид байлгах зорилгоор төмөр зам барих эрхийг шууд гэрээгээр олгох, Богдхан уулын урдуур тавих 130 км төмөр замын суурь бүтцийг барих эрхийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх тухай Зам, тээврийн яамнаас 2012 оны 10 дугаар сарын 30-ны 1/227 дугаар албан бичиг ирүүлсэнтэй Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд танилцаад асуудлыг Засгийн газраар хэлэлцүүлсний дараа авч үзэх шаардлагатай гэсэн чиглэл өгсөн бол Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг байгуулах тухай Монгол-Оросын Засгийн газар хоорондын 1949 оны хэлэлцээрийг шинэчлэх ажлын явцын тухай танилцуулга болон “Шинэ төмөр зам” төслийн хэрэгжилтийн явцын тухай танилцуулга, “УБТЗ байгуулах тухай хэлэлцээр, нийгэмлэгийн дүрмийг шинэчлэх ажлын явц, цаашид баримтлах чиглэлийн тухай” танилцуулгатай тус тус танилцан чиглэл өгөн ажиллаж байна.

#### Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт Хүчний Ерөнхий Командлагчийн хувьд

Зэвсэгт хүчнийг мэргэжлийн чиг баримжаатай чадварлаг болгох төрийн бодлогын хэрэгжилтийн явц, Зэвсэгт хүчний байгуулалтыг боловсронгуй болгон

хөгжүүлэх арга хэмжээний үр дүнгийн талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газрын дарга нарын илтгэл, мэдээллийг сонсож, чиглэл өгсөнөөс гадна зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнтэй уулзаж ярилцан үүрэг өгч ажиллав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 14 дүгээр зарлигаар 2006 оны 349 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол Улсын Бүх цэргийн Их хар сүлдийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт; мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 217 дугаар зарлигаар батлагдсан “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын төрийн тусгай албан хаагчийн цол олгох журам”-д 2013 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 90 дүгээр зарлигаар тус тус өөрчлөлт орууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Ц.Элбэгдорж 2013 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Өмнөд Судан Улсад НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож буй монгол цэргүүдээ эргэлээ. Энэ үеэр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүн утсаар ярьж талархал илэрхийллээ. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчид НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын тусгай төлөөлөгч, хатагтай Хилде Ф.Жонсон бараалхсан юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Ц.Элбэгдорж НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын тусгай төлөөлөгч, хатагтай Хилде Ф.Жонсонтой ярилцах үеэрээ “Бид НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхлээд 10 жил болж байна. Олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй гүйцэтгэхийн зэрэгцээ манай зэвсэгт хүчин улам бүр туршлага хуримтлуулж, үүрэг гүйцэтгэх чадвар нь дээшилж байгаад Монгол Улс сэтгэл ханамжтай байдаг. Цаашид ч бид энэ төрлийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байх болно” хэмээн онцлон тэмдэглэв.

Монгол Улсын Бүх цэргийн Их хар сүлдийн дүрэмд заасны дагуу Бүх цэргийн Их хар сүлдийн цэнгүүлэх тайлга 2013 оны 06 дугаар сарын 11-ний өдөр болж Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Ц.Элбэгдорж оролцлоо.

Монгол Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Зэвсэгт хүчний хамтарсан “Нүүдэлчин Заан 2013” хээрийн сургалт, дадлага 2013 оны 06 дугаар сарын 13-нд Хужирбулан дахь Тусгай хүчний сургалтын төвд эхэлсэн. Энэхүү хээрийн сургалт, дадлагын үеэр хоёр улсын тусгай хүчний цэргийн албан хаагчид энхийг сахиулах, терроризмтай тэмцэх чиглэлээр харилцан туршлага солилцож, мэдлэг чадвараа ахиулсан юм.

“Khaan Quest-2013” энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургууль 08 дугаар сарын 03-наас 14-ний өдрүүдэд Тавантолгой дахь Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвд болж Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Япон Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс зэрэг 13 орны 153 цэргийн албан хаагч оролцлоо. Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсууд ажиглагчаар оролцсон.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 143 дугаар зарлигаар Цагдаагийн дүрэмт хувцасны загварыг баталлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын 2013 оны марш тактикийн аварга шалгаруулах тэмцээн 5 дахь удаагаа зохион байгуулагдсан бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Ц.Элбэгдорж тэмцээний ач холбогдлыг "... уралдах, өрсөлдөх гэхээсээ илүүтэйгээр Зэвсэгт хүчин, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан суралцах, мэдлэг туршлагаа хуваалцах боломж, нөхцөлийг бүрдүүлж байгаагаар авч үзвэл зохистой" хэмээснийг тус марш тактикийн тэмцээний хаалтын ажиллагаанд оролцсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга П.Цагаан уламжиллаа.

### **ГУРАВ. ГАДААД ХАРИЛЦААНЫ ТАЛААРХИ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХИЙН ХҮРЭЭНД**

Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсыг гадаад харилцаанд бүрэн эрхтэй төлөөлж, гадаад бодлого, олон улсын хэмжээнд идэвхитэй үйл ажиллагаа явуулах чиглэлийг барьж ажиллав. Үүний дүнд олон улс болон бүс нутгийн хэмжээнд Монгол Улсын байр суурь, нэр хүндийг бэхжүүлэх, сурталчлан таниулах, Монгол Улс тогтвортой хөгжих гадаад таатай орчинг бэхжүүлэхэд өнгөрсөн нэг жилийн хугацаанд тодорхой ахиц гарсан хэмээн дүгнэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Бүгд Найрамдах Польш Улсын Ерөнхийлөгч Бронислав Коморовскийн урилгаар тус улсад 2013 оны 01 дүгээр сарын 21-22-нд төрийн айлчлал хийх үеэр Талууд барилга, хот байгуулалт, зам тээвэр, хөдөө аж ахуй, мал эмнэлэг, газар тариалан, уламжлалт анагаах ухаан, эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах, туршлага солилцох, хоёр талын батлан хамгаалахын салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар ярилцсанаар Монгол-Польшийн харилцаа, хамтын ажиллагааг бататгах, өндөр дээд хэмжээний айлчлал, яриа хэлэлцээний түвшинг хадгалах ач холбогдолтой болов.

Айлчлалын үеэр "Монгол Улсын БШУЯ, БНПУ-ын Шинжлэх ухаан, дээд боловсролын яам хооронд дээд боловсролын салбарт хамтран ажиллах тухай хөтөлбөр", "Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай БНПУ-ын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр", "Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн яам, БНПУ-ын Бүсийн хөгжлийн яам хоорондын Бүс нутгийн хамтын ажиллганы чиглэлээр хамтран ажиллах Санамж бичиг", Монгол Улсын ШУА, Польшийн ШУА хооронд хамтран ажиллах тухай Хэлэлцээр", "Гүйцэтгэх протокол"-д холбогдох албаны хүмүүс тус тус гарын үсэг зурав. Мөн тухайн улсад ажиллаж амьдарч сурч буй Монгол Улсын иргэдтэйгээ уулздаг уламжлал ёсоороо энэ үеэр Бүгд Найрамдах Польш Улсад амьдарч ажиллаж байгаа иргэдийн төлөөлөлтэй уулзав.

Швейцарийн Холбооны Улсын Давос хотноо чуулсан Дэлхийн Эдийн засгийн Чуулга уулзалтын үеэр (2013.01.23-26) Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж нэгдсэн хуралдаан, ДЭЗЧУ-ын Авлигын эсрэг түншлэлийн санаачилга, уул уурхай, ус, ногоон хөгжлийн асуудлаарх салбар хуралдаанууд, мөн Дэлхийн Эдийн засгийн удирдагчдын албан

бус уулзалтын хүрээнд болсон Арабын хаврын геополитикийн нөлөө, 2013 онд тулгамдаж буй асуудлууд, 2015 оноос хойших хөгжлийн зорилтууд, аюулгүй байдлын асуудлаарх хуралдаануудад оролцлоо. Мөн CNN-ийн "Global Exchange" шууд нэвтрүүлэг болон ДЭЗЧУ байгууллагаас бэлтгэж байгаа Авлигын эсрэг санаачилгын тухай баримтат кинонд ярилцлага өглөө. Чуулга уулзалтын үеэр Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж ДЭЗЧУ байгууллагын дарга проф.Клаус Шваб, Коста Рикагийн Ерөнхийлөгч Лаура Чинчилла, Финландын Ерөнхийлөгч Саули Нийнисто, Швейцарын Ерөнхийлөгч Сума Чакрабарти, "Нестле" группын Захирлуудын зөвлөлийн дарга Петер Брабек-Летмате, Харвардын Их сургуулийн удирдлагатай хоёр талын уулзалт хийв.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2013 оны 09 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Киргиз Улсын Бишкек хотноо болсон Шанхайн хамтын ажиллагааны байгууллага /ШХАБ/-ын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн 13-р хуралдааны өргөтгөсөн хуралдаанд оролцов. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс, Лалын Бүгд Найрамдах Иран Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын төлөөлөгчдийн тэргүүн нар хийгээд ШХАБ-ын Ерөнхий Нарийн Бичгийн Даргатай хоёр талын уулзалтууд хийсэн нь тэдгээр орон, ШХАБ-тай хөгжүүлж буй хамтын ажиллагааны хөгжилд түлхэц үзүүлсэн алхам болов. Түүнчлэн өмнө нь өндөр, дээд түвшинд хийсэн хоёр талын уулзалтуудаар харилцан тохиролцсон зүйлсийг түргэтгэхэд тустай арга хэмжээ болов.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2013 оны 09 дүгээр сарын 23-27-ны өдрүүдэд Нью-Йорк хотноо ажиллаж НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 68-р чуулганы Ерөнхий санал шүүмжлэл, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар Ерөнхий Ассамблейн өндөр төвшний хуралдаан, Мянганы хөгжлийн зорилтуудыг эрчимжүүлэх асуудлаарх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн өндөр төвшний хуралдаан болон чуулганы үеэр зохион байгуулсан бусад арга хэмжээнд оролцов. Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын олон улсын судалгааны төвийг санаачлан байгуулсан. Уг төвийн үйл ажиллагааг албан ёсоор эхлүүлэхийн тулд холбогдох гэрээ хэлэлцээрт нэгдэн орж соёрхон батлахыг Монгол Улсын Ерөнхийлөгч далайд гарцгүй бусад улс оронд хандан уриалав.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2013 оны 10 дугаар сарын 28-31-нд Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсад төрийн айлчлал хийв. Айлчлалын үеэр Мансүдэгийн Ардын Их Хурлын ордонд Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж, БНАСАУ-ын Ардын дээд Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ким Ён Нам нар албан ёсны хэлэлцээ хийлээ.

Хэлэлцээний дараа Монгол Улс, БНАСАУ-ын харилцаа, хамтын ажиллагааны баримт бичгүүдэд гарын үсэг зурах ёслол болсон бөгөөд Үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах тухай БНАСАУ-ын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Соёл, спорт, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай БНАСАУ-ын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Зам тээврийн салбарт хамтран ажиллах тухай БНАСАУ-ын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг шинэчлэн байгуулах тухай протокол, БНАСАУ-ын Программ хангамжийн ерөнхий газар, Монгол

Улсын мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын хооронд 2013-2015 онд хамтран ажиллах ажлын төлөвлөгөөнд холбогдох албаны хүмүүс тус тус гарын үсэг зурлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Монгол, Солонгосын бизнесийн уулзалтад оролцож үг хэллээ. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж БНАСАУ-д хийсэн төрийн айлчлалынхаа үеэр Ким Ил Суны их сургуульд зочлон, эрдэмтэн багш, оюутнуудад лекц уншив. Монгол Улсын Ерөнхийлөгч айлчлалынхаа хоёр дахь өдөр БНАСАУ-ын Панмүнжоны цэрэггүй бүсэд зочиллоо.

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч Тейн Сейний урилгаар 2013 оны 11 дүгээр сарын 18-21-ний өдрүүдэд тус улсад төрийн айлчлал хийв.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч Тейн Сейнтэй Ерөнхийлөгчийн ордонд уулзалт хийсний дараа албан ёсны хэлэлцээ хийв. Хэлэлцээний дараа хоёр орны харилцааны баримт бичгүүдэд гарын үсэг зурах ёслолын арга хэмжээ болж, Дипломат болон албан паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас харилцан чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт Монгол Улсын Гадаад харилцааны сайд Л.Болд, Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсын Гадаад хэргийн сайд Вунна Маунг Лвин нар гарын үсэг зурав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсад хийсэн төрийн айлчлал нь төрийн тэргүүний хувьд тус улсад хийсэн анхны айлчлал болсон бөгөөд Мьянмар Улстай харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлэх, дээд, өндөр төвшний яриа хэлэлцээг эхлүүлэхэд чухал хувь нэмэр оруулав. Түүнчлэн, ардчилсан шилжилтийн замыг сонгон шилжилтийн үйл явцыг эхлүүлээд буй Мьянмар Улсад Монгол Улсын ардчилсан шилжилт, шүүхийн шинэчлэл, төрийн албаны шинэтгэл хийсэн туршлага болон бүс нутаг болон олон улсын тавцанд хамтран ажиллах өргөн хүрээний асуудлаар санал солилцоход чухал ач холбогдолтой боллоо.

Айлчлалын үеэр Монгол, Мьянмарын бизнес форум зохион байгуулж, хоёр орны эдийн засгийн байдал, гадаадын хөрөнгө оруулалтын орчны талаар харилцан мэдээлэл солилцсон нь худалдаа, эдийн засгийн харилцаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг эхлүүлэн хөгжүүлэхэд тодорхой үр дүн өгөхөөс гадна хоёр орны бизнес эрхлэгчдийн хооронд шууд холбоо тогтооход чухал ач холбогдолтой болов.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ерөнхийлөгч Чыонг Тан Сангийн урилгаар 2013 оны 11 дүгээр сарын 21-24-ний өдрүүдэд БНСВУ-д төрийн айлчлал хийлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж БНСВУ-ын Ерөнхийлөгч Чыонг Тан Сангтай Ерөнхийлөгчийн ордонд хэлэлцээ хийв.

Хэлэлцээний дараа хоёр орны харилцааны баримт бичгүүдэд гарын үсэг зурах ёслолын арга хэмжээ болов. Монгол Улсын Гадаад харилцааны яам, БНСВУ-ын Гадаад хэргийн яам хооронд хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын Санамж

бичиг, Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Батлан хамгаалах яам, БНСВУ-ын Үндэсний батлан хамгаалах яам хоорондын харилцан ойлголцлын Санамж бичиг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын Хууль зүйн яам, БНСВУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яам хоорондын хэлэлцээр, Газрын тос, хийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Газрын тосны газар болон Вьетнамын “Оил энд газ” групп хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт холбогдох албаны хүмүүс тус тус гарын үсэг зурав.

Энэхүү айлчлал нь БНСВУ-тай уламжлалт найрсаг харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх, дээд, өндөр төвшний яриа хэлэлцээний давтамжийг хадгалах, эдийн засгийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргахад чухал ач холбогдолтой болов.

Түүнчлэн, бүс нутаг болон олон улсын харилцан сонирхсон асуудлаар санал солилцох, Монгол Улс цаашид АСЕАН-ы яриа хэлэлцээний түнш болох, АПЕК-т гишүүнээр элсэх зэрэг асуудалд Вьетнам Улсын дэмжлэгийг авахад тодорхой хувь нэмэр оруулсан гэж үзэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Бүгд Найрамдах Сингапур Улсын Ерөнхийлөгч Тони Тан Кенг Яамын урилгаар 2013 оны 11 дүгээр сарын 24-27-ны өдрүүдэд Сингапур Улсад төрийн айлчлал хийлээ.

Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж айлчлалынхаа үеэр Бүгд Найрамдах Сингапур Улсын Ерөнхийлөгч Тони Тан Кенг Яамтай уулзаж, хоёр орны хоорондын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлаар санал солилцов.

Сингапур Улсын Ерөнхий сайд Ли Хсиен Лүүнг Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржид бараалхав.

Талууд айлчлалын үеэр гарын үсэг зурсан Монгол Улсын Гадаад харилцааны яам, Сингапур Улсын Гадаад хэргийн яам хоорондын Бодлогын зөвлөлгөөний тухай Харилцан ойлголцлын санамж бичгийг сайшааж, гадаад бодлогын яамд хооронд байнгын зөвлөлдөх механизм бий болж, хоёр талын улс төрийн яриа хэлэлцээг идэвхжүүлэн, харилцан мэдээлэл солилцох, хамтын ажиллагааны оновчтой чиглэл, хэлбэрийг тодорхойлох, мөн бүс нутгийн болон олон улсын харилцан сонирхсон асуудлаар зөвлөлдөх зэрэг хамтын ажиллагааг өргөжүүлэхэд зохих үр дүнгээ өгнө гэдэгт санал нэгдэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сингапур Улсад хийсэн айлчлал нь Монгол, Сингапурын харилцаанд томоохон түлхэц болж, хоёр ард түмний найрсаг харилцааны түүхийг баяжуулан, өндөр, дээд хэмжээний яриа хэлэлцээний давтамжийг нэмэгдүүлэх, хоёр талын улс төрийн яриа хэлэлцээг гүнзгийрүүлэх, харилцан ойлголцлыг бэхжүүлэх, хамтын ажиллагааг худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, хот төлөвлөлт, хотын менежмент, барилга, орон сууц, баялагийн сан бүрдүүлэх, даатгал, санхүү, шинжлэх ухаан, боловсрол, хууль эрх зүй зэрэг чиглэлээр цаашид эрчимжүүлэхийн зэрэгцээ Монгол Улсын ардчилал, нийгэм, эдийн засгийн өнөөгийн хөгжил, мөн бүс нутгийн интеграцлалд нэгдэх манай улсын байр суурь, зорилтуудыг таниулан мэдүүлэхэд чухал алхам болов.

Айлчлалын үеэр Монгол Улсын төрийн өмчийн оролцоотой компаниудыг үр ашигтай ажиллагаанд шилжүүлэх тогтолцоог бий болгох ажлын хүрээнд Төрийн өмчийн хороог ТЕМАСЕК хэлбэрээр өөрчлөх замаар хэрэгжүүлэх, улмаар Монгол Улсын эдийн засгийн цаашдын хөгжлийн загварыг гаргах ажлыг хамтран хэрэгжүүлэхээр ТЕМАСЕК-ийн удирдлагатай ярилцан тохирч, энэ асуудлаар тэдний талаас баг ирж ажиллахаар болсон нь айлчлалын нэг чухал үр дүн юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгт 2013 оны 11 дүгээр сарын 27-28-нд ажиллаа.

Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Экономист сэтгүүлээс зохион байгуулсан “Дэлхий 2014 онд” олон улсын эдийн засгийн арга хэмжээнд оролцож, Монгол, Хонконгийн бизнес форумын нээлтийн ажиллагаанд оролцож, үг хэлэв.

Ерөнхийлөгчийн Хонконгт ажиллах хүрээнд Эрүүгийн хэргийн асуудлаар харилцан туслалцаа үзүүлэх тухай, мөн Ялтан шилжүүлэн өгөх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрүүдэд Талууд 2014 оны дундуур гарын үсэг зурж баталгаажуулахаар тохиролцов.

Ийнхүү Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд заасны дагуу Азийн бусад улстай хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх, Ази, Номхон далайн бүс нутагт олон талт хамтын ажиллагаанд оролцох, Зүүн Ази, Зүүн хойд Ази, Төв Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлогын хүрээнд Азийн зарим улсуудад төрийн айлчлал хийж ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах асуудлаар зөвшилцөх тухай 2013 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн Е/2, мөн оны 10 дугаар сарын 07-ны өдрийн Е/7 дугаартай албан бичгийг Улсын Их Хуралд Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасныг тус тус үндэслэн хүргүүлж шийдвэрлэсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар Бүгд Найрамдах Польш Улсын Ерөнхийлөгч Бронислав Коморовски 2013 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Монгол Улсад ажлын айлчлал хийв. Энэхүү айлчлал нь Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн 2013 оны 1 дүгээр сард Бүгд Найрамдах Польш Улсад хийсэн айлчлалын хариу айлчлал байв.

Айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Бүгд Найрамдах Польш Улсын Ерөнхийлөгч Бронислав Коморовскитай уулзалт болон албан ёсны хэлэлцээ хийв.

Уулзалт, хэлэлцээний үеэр талууд хоёр орны харилцааны өнөөгийн байдлыг дүгнэн ярилцахын зэрэгцээ цаашид хоёр талын хамтын ажиллагааг бүхий л салбарт өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлох талаар дэлгэрэнгүй ярилцаж, санал солилцов. Мөн ардчиллыг бэхжүүлэх, дэлгэрүүлэх үйлсэд оруулсан хувь нэмрийг үнэлж буйгаа хоёр талаас харилцан илэрхийлэхийн сацуу цаашид энэ чиглэлд идэвхтэй хамтран ажиллахаар тохиролцов.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар Канад Улсын Амбан захирагч Эрхэмсэг ноён Дэвид Жонстон 2013 оны 10 дугаар сарын 24-26-нд Монгол Улсад төрийн айлчлал хийв.

Айлчлалын үеэр Канад Улсын Амбан захирагч Дэвид Жонстон Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж нар албан ёсны уулзалт хийлээ. Албан ёсны уулзалтын үеэр Монгол, Канадын харилцааны нөөц бололцоог дайчлах, хөдөөгийн хөгжил, эрүүл мэнд, барилга, соёл, спорт, урлаг, аялал жуулчлал, энхийг сахиулах чиглэлээр хамтран ажиллах асуудлыг хөндөж ярилцсан нь эдгээр салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэхэд түлхэц үзүүлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар Европын Комиссын Ерөнхийлөгч Жозе Мануэл Баррозо 2013 оны 11 дүгээр сарын 17-18-ний өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийв.

Айлчлалын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Европын Комиссын Ерөнхийлөгч Ж.М.Баррозотой уулзаж, албан ёсны хэлэлцээ хийв.

Уулзалт, хэлэлцээний үеэр талууд хоёр талын харилцааны өнөөгийн байдлыг дүгнэн ярилцахын зэрэгцээ цаашид хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх талаар дэлгэрэнгүй ярилцав. Мөн худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт болон хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар дэлгэрэнгүй санал солилцов.

Монгол Улсын “гуравдагч хөрш” болох Европын Холбооны талаас өндөр төвшинд хийгдэж буй энэхүү анхны айлчлал нь түүхэн ач холбогдолтой байсан бөгөөд хоёр талын улс төрийн дотно харилцаа, итгэлцлийг бататгах, хамтын ажиллагааг түншийн хэмжээнд хүргэх, Монгол Улсын нэр хүндийг Европын Холбоо, түүний гишүүн орнууд төдийгүй дэлхий дахинд бэхжүүлэхэд чухал алхам болов.

2013 оны 04 дүгээр сарын 27-29-ний өдрүүдэд Ардчилсан Орнуудын Хамтын Нийгэмлэгийн Сайд нарын VII Бага хурлыг эх орондоо зохион байгуулж, дарга орны албыг Эль Сальвадор Улсад хүлээлгэн өглөө. Сайд нарын Бага хурлын дүнгээр гаргасан Улаанбаатарын Тунхаглал, түүний бүрэлдэхүүн хэсэг болох чуулга уулзалтуудын Зөвлөмжүүдийг батлан гаргалаа. Бага хурлын хүрээнд Ази, Номхон далайн орнуудын Гадаад хэргийн сайд нарын албан бус анхдугаар хуралдааныг зохион байгуулав. Мөн АОХН-ийн Удирдах Зөвлөлийн 8-р хуралдаан болов. Монгол Улс дэлхийн ардчилсан бүх орныг эгнээндээ нэгтгэсэн АОХН-ийг даргалах, түүний үйл ажиллагааг тодорхой санаачилгатай дэмжиж ажилласнаар тус орон Ази тивд төдийгүй дэлхий дахинаа ардчиллын загвар орон болж чаджээ гэж Бага хуралд оролцогчид дүгнэлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн сайд нарын VII бага хурлыг нээж хэлсэн үгэндээ (“Энэ дэлхийд хүн бүр эрх чөлөөтэй, энх амгалан амьдрах боломжтой”) Монгол Улс Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийг даргалсандаа баяртай байна гээд “... Энэ хооронд Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх Хороог байгууллаа. Орон тооны Ерөнхий нарийн бичгийн дарга томилогдлоо. НҮБ-ын дэргэдэх ардчилсан орнуудын бүлгийн ажил тогтмолжлоо. НҮБ-ын Женев дэх салбарт Ардчилсан

орнуудын хамтын нийгэмлэгийн бүлэг ажиллаж эхэллээ. Ардчиллын шинэ удирдагчдын сүлжээ байгуулагдаж ажилдаа орлоо.

Бид Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийг даргалах хугацаандаа ардчиллын боловсролын асуудалд онцгой анхаарсан. Энэ асуудлаар гишүүн орнуудын төр, засгийн тэргүүн нарын төвшинд санаачилгын бүлэг байгууллаа. Гишүүн орнуудын хүчин чармайлтын үр дүнд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 67 дугаар чуулган ардчиллын боловсролын асуудлаар анх удаа бие даасан, түүхэн тогтоол баталлаа.

Монгол Улс анх удаа “Авлигыг үл тэвчих санаачилга”-ыг Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн хүрээнд дэвшүүлж, уг асуудлыг энэ байгууллагын анхаарлын төвд оруулж чадлаа. Энэ удаагийн бага хурал авлигын сэдвийг тусгайлан авч хэлэлцсэнд талархаж байна. Мөн “Ардчиллын төлөө Азийн түншлэл” санаачилга хэрэгжиж эхэллээ. “Азийн ардчиллын сүлжээ” үүсч, хоёр жил тутам бүс нутгийн ардчиллын үйл явцад үнэлэлт, дүгнэлт өгч байхаар боллоо. Бид иргэний нийгмийг бэхжүүлэх, туршлага, сургамжаа хуваалцах чиглэлд идэвхтэй хамтран ажиллаж чадлаа.”

...Монгол Улс саяхан “Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаар Улаанбаатарын яриа хэлцэл” хэмээх санаачилгыг дэвшүүлсэн. Монголын ард түмэн бол зочломтгой, хэцүү асуудалд хамтын шийдэл олохыг хичээдэг хүмүүс. Манай орон Солонгосын хойгийн зөрчилдөөнийг энхийн замаар шийдвэрлэхэд туслахыг хүсч байна. Энэ зорилгоор бид мухардалд ороод байгаа зарим асуудалд шинэ үүд хаалга нээхийг эрмэлзэж байна. Улаанбаатарт сонирхогч талуудыг уулзаж, яриа хэлцэл хийхийг урьж байна” хэмээн хэллээ.

Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Сайд нарын VII бага хуралд нийт 104 орны 1215 зочид төлөөлөгчид оролцсоны дотор Тайландын Вант Улсын Ерөнхий сайд, тус хурлын хүндэт зочин, эрхэмсэг хатагтай Инглак Шинэватра, Коста Рика Улсын Тэргүүн дэд Ерөнхийлөгч ноён Алфио Пива Месен, Холбооны Бүгд Найрамдах Нигери Улсын Дэд Ерөнхийлөгч ноён Намади Самбо, Европын Холбооны Гадаад хэрэг, аюулгүй байдлын бодлогын дээд төлөөлөгч, Европын Комиссын Дэд Ерөнхийлөгч, хатагтай Баронесс Катрине Эштон, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч ноён Касийм Жомарт Токаев, Нобелийн энх тайвны шагналт эрхэмсэг хатагтай Ан Сан Су Чи, Нобелийн энх тайвны шагналт эрхэмсэг хатагтай Тавакул Карман нарын нэр хүндтэй, эрхэм зочид олон хүрэлцэн ирсэн юм.

Энэ үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, түүний урилгаар Монгол Улсад айлчилсан Мьянмарын ардчилал, хүний эрхийн төлөө тэмцэгч, Ардчиллын төлөө Үндэсний Лиг намын тэргүүн, Нобелийн шагналт хатагтай Ан Сан Су Чи нар “Монгол ба Мьянмар: Эрх чөлөө, ардчилалд хүрэх замд” хамтарсан лекц уншив.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Европын Холбооны Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын парламентын ассамблейн Ерөнхийлөгч Рикардо Мильори тэргүүтэй төлөөлөгчид (2013.03.13), Азийн хөгжлийн банкны Ерөнхийлөгч, захирлуудын зөвлөлийн дарга Такэхико Накао (2013.07.15), Дэлхийн банкны Дэд Ерөнхийлөгч Аксел Вант Троценбург (2013.09.19) болон бусад гадаад улсын төлөөлөгчдийг Төрийн ордонд хүлээн авч уулзлаа.

## ДӨРӨВ. ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БУСАД БҮРЭН ЭРХИЙН ХҮРЭЭНД

2013 онд Монголын Тулгар төрийн 2222 жилийн ой, Их Монгол Улсын 807 жилийн ой, Үндэсний эрх чөлөөний хувьсгалын 102 жилийн ой, Ардын хувьсгалын 92 жилийн ой, Архангай, Төв, Завхан, Хэнтий аймаг байгуулагдсаны 90 жилийн ой, Хил Хамгаалах байгууллагын 80 жилийн ой, Багануур ХК-ийн 35 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнуулахаар 12700 иргэний тодорхойлолт материалыг Ерөнхийлөгчийн Тамгын газарт холбогдох яам, орон нутгийн Засаг захиргаа, төрийн бус байгууллагаас ирүүлсэнтэй танилцаж, судалж эдгээрээс 5371 иргэнийг төрийн цол, одон медалиар шагнаж урамшуулсан бөгөөд энэ тоонд гадаадын иргэд, уяач, бөх, харваачдад олгосон цол болон Энхийн төлөө медалиар шагнагдсан иргэдийн тоо орсон юм.

2013 онд 7806 эхэд Алдарт эхийн I, II одон олгосон байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2012 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр “Чингис хаан – Тэмүжиний мэндэлсэн огноог албан ёсны болгож, ёсчлох тухай” 04 дүгээр зарлигтаа “... Чингис хаан – Тэмүжиний мэндэлсэн огноог билгийн тооллын гуравдугаар жарны усан морин жил буюу 1162 оны өвлийн тэргүүн сарын шинийн нэгний өдөр хэмээн үзсүгэй, Их хааны мэндэлсэн өдрийг “Монгол бахархалын өдөр” гэж нэрийдэж бүх нийтээр ёслон тэмдэглэж байсугай” хэмээн зарлиг болгосон билээ.

Улсын Их Хурлын “Чингис хаан” одон бий болгох тухай 2002 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 21 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын 2012 оны 56 дугаар тогтоолоор “Чингис хаан” одонг Их Эзэн Чингис хаан мэндэлсэн билгийн тооллын өвлийн тэргүүн сарын шинийн 1-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар олгож байх; “Чингис хаан” одонд нэр дэвшүүлэх, шагнах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоохоор шийдвэрлэсэн.

Дээрх шийдвэрийн дагуу, Монгол Улсын төр нийгмийн нэрт зүтгэлтэн Думаагийн Содномыг Монгол Улсын төрийн дээд шагнал, Тэргүүн зэргийн одон “Чингис хаан” одонгоор шагнасан.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 171 дүгээр зарлигаар “Чингис хаан” одонд нэр дэвшүүлэх, шагнах журмыг баталлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчид хандан уучлал үзүүлэхийг хүссэн болон бусад (өршөөл, цагаатгал) нийт 265 иргэний өргөдөл материалыг хүлээн авав. Уг өргөдлийг хянан үзэж, хуулийн шаардлага хангаагүй болон урд өмнө хариу өгсөн асуудлаар хандсан 135 өргөдлийг буцаах хариу өгч, хуулийн шаардлага хангасан гэж үзсэн 130 өргөдөл хүсэлтэд судалгаа хийж танилцуулснаас Монгол Улсын Ерөнхийлөгч 3 хүнд уучлал үзүүлж, 127 хүнд уучлал үзүүлэхээс татгалзсан.

Монгол Улсын харъяат болох, Монгол Улсын харъяатаас гарах зэрэг асуудлаар ирүүлсэн хүсэлтийг хуулийн дагуу судлан үзэж шийдвэрлэсэн.



2013 онд Ерөнхийлөгчид хандсан 2271 албан бичиг, 1953 захидал иргэд, олон нийтээс ирүүлснийг хүлээн авч зохих хууль, журмын дагуу шийдвэрлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч өнгөрсөн нэг жилийн хугацаанд УИХ-ын нэгдсэн чуулган, Засгийн газрын хуралдаан, үндэсний хэмжээний хурал зөвлөгөөн, хэлэлцүүлэг, баяр ёслол, иргэдтэй хийсэн уулзалт дээр болон ард түмэндээ хандан нийт 39 удаа үг хэлэв.

Мөн аймгийн болон нийгмийн салбарын ойн баяр, үндэсний хэмжээний арга хэмжээ /хурал зөвлөгөөн, чуулга уулзалт гэх мэт/-нд оролцогсдод хандан баяр хүргэж, амжилт гаргах, шийдвэрлэвэл зохих асуудалд анхаарлаа хандуулахыг хүсч 23 удаа Монгол Улсын Ерөнхийлөгч мэндчилгээ, илгээлт хүргүүлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч хичээлийн шинэ жилийн нээлтэд зориулан уламжлал ёсоор 5 дахь жилдээ Монголын үндэсний олон нийтийн телевизээр “Хуулийн засаглал Хүүхдийн оролцоо” сэдвээр ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад нэг цагийн хичээл зааж энэ хичээлийг МҮОНТ шууд орон даяар дамжуулж ерөнхий боловсролын бүх сургуулийн сурагчдад хүргэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн баримталж буй бодлого, үйл ажиллагааг олон нийтэд хүргэж иргэдийг мэдээлэлжүүлэх, үйл явдлын мэдээг хугацаа алдалгүй хүргэхийн тулд [www.president.mn](http://www.president.mn) веб хуудсыг монгол бичгээр болон монгол, англи хэл дээр тогтмол ажиллуулж, иргэдийн санаа бодлыг цахим хэлбэрээр хүлээн авч ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2013 оны 03 дугаар сарын 16-ны өдөр нийслэлийн Баянзүрх дүүргийн алслагдсан захын 23 дугаар хороонд очиж иргэд, оршин суугчидтай уулзаж, иргэдийн саналыг сонсож ярилцлаа. Мөн энэ өдөр Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгээр орж, ажил байдалтай нь танилцав.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2013 оны 03 дугаар сарын 24-25-нд Өвөрхангай аймгийн Бүрд сумын Боргидой багт ажиллаж Иргэдийн нийтийн хуралд ажиглагчаар оролцов. 2013 оноос “Төсвийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Орон нутгийн хөгжлийн сангаас хуваарилагдсан хөрөнгийг хэрхэн хуваарилж, зарцуулах талаар хэлэлцэж байгаа үйл ажиллагаатай танилцаад “Улсаа өөд татах гэвэл баг, сумаасаа эхлэх нь зөв. Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөө ч ийм л зорилготойгоор зарцуулах хэрэгтэй. Одоо энэ онд энэ санд нийт төвлөрч байгаа 250 орчим тэрбум төгрөг гэдэг бол хориод жилийн өмнөх манай улсын ДНБ-тэй бараг тэнцэх мөнгө шүү. Маш их мөнгө. Зөв зарцуулах хэрэгтэй. Сайн ярилц, хэлэлц” хэмээн багийн иргэдэд зөвлөв.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч 2013 оны 09 дүгээр сарын 20-нд Төв аймгийн Баянцогт, Баянчандмань суманд ажиллаж иргэдтэй уулзаж санаа бодлыг нь сонсож, зарим аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч Нийслэлийн иргэдийн төлөөлөлтэй уламжлал ёсоор 2013 оны 05 дугаар сарын 04-нд Төрийн ордны Их танхимд иргэдийн төлөөлөл 800 гаруй хүнтэй уулзалт хийв. Монгол Улсын Ерөнхийлөгч иргэдтэй хийсэн уулзалтад оролцождоо хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хийж буй ажлаасаа

тодорхой чиглэлүүдээрх мэдээллийг иргэд, олон нийтэд өгч тэдний сонирхсон асуултад хариулав.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2013-2017 онд хэрэгжүүлэх Бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрөө 2013 оны 08 дугаар сарын 29-ний өдөр 142 дугаар зарлигаараа баталлаа. Энэхүү хөтөлбөр нь “Хуулийн засаглалтай улс, Иргэний оролцоотой шийдэл, Бүтээгчдээ дэмжсэн бодлого, Байгальд ээлтэй хөгжил, Дэлхийд нэртэй Монгол, Бусад” гэсэн зургаан үндсэн чиглэлтэй.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа зарим ажлын явцын талаар тоймлон танилцуулбал:

#### Хуулийн засаглалтай улс

Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр /2013-2017 он/-ийн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлах нэр бүхий 11 хуулийн төслийг шинээр боловсруулах ажлын хэсгүүдийг байгуулж, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгүүдийн баримталж ажиллах нэгдсэн удирдамжийг баталлаа. Эдгээр ажлын хэсэгт орж ажиллах сонирхолтой иргэдийг оролцуулах зорилгоор урилга гаргаж урилгын дагуу хүсэлтээ илэрхийлж бүртгүүлсэн иргэдээс сонголт хийж ажлын хэсэгт 68 иргэнийг оролцуулсан.

- 1/ Аюулгүй байдал, батлан хамгаалахын тухай багц хууль;
- 2/ Нийтийн зар мэдээний тухай хууль;
- 3/ Иргэн, харъяатын тухай хууль;
- 4/ Шилэн дансны тухай хууль;
- 5/ Үйлдвэржилтийн тухай хууль;
- 6/ Өмчийн эрхийн тухай хууль;
- 7/ Хотын тухай хууль;
- 8/ Сургуулийн өмнөх насны хүүхэд асрах бичил цэцэрлэгийн тухай хууль;
- 9/ Ард нийтийн санал асуулгын тухай хууль;
- 10/ Хүний эрхийн тухай хууль;
- 11/ Шагналын тухай хууль.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Том төрөөс ухаалаг төр рүү” үндэсний зөвлөлдөх уулзалтыг 2013 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Төрийн ордонд зохион байгууллаа. Уулзалтад шийдвэр гаргагчид, бизнес эрхлэгчид, эрдэмтэн судлаачид, олон нийтийн байгууллага, хэвлэл мэдээллийнхний төлөөллийг оролцуулсан.

Уулзалтын гол зорилго нь дээр дурдсан олон хүрээний төлөөлөл нэгэн зүйл асуудлыг буюу Монгол Улсад бий болсон өнөөгийн төр, нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал, тулгамдсан сорилтуудыг шүүн ярилцаж, ойрын ирээдүйд зайлшгүй хийх хэтийг харсан алхмуудыг тодорхойлох, бүгд нэгдсэн ойлголтод хүрэх явдал байсан бөгөөд энэ талаарх Ерөнхийлөгчийн санал, санаачлага бүхий үгийг сонсож, улмаар Шийдвэр гаргагчдын салбар хуралдаан, Бизнес эрхлэгчдийн салбар хуралдаан, Орон нутгийн төлөөллийн салбар хуралдаан, Эрдэмтэн судлаачдын

төлөөллийн салбар хуралдаан, Хэвлэл, мэдээллийн төлөөллийн салбар хуралдаан зохион байгууллаа. Салбар хуралдаанаар Ерөнхийлөгчийн хэлсэн үгэндээ хөндөн тавьсан, дэвшүүлсэн олон асуудлыг нухацтай хэлэлцэж, санал санаачилгуудыг нь дэмжихийн сацуу тэдгээрийг ажил хэрэг болгох үүднээс өөр өөрсдийн саналыг илэрхийлж нэгтгэсэн. Дараа нь нэгдсэн хуралдаан хийж нэгтгэсэн саналаа оролцогчдод танилцууллаа.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн “Том төрөөс ухаалаг төр рүү” санаачилгыг дэмжиж, судалгаанд суурилсан, үйлчилгээнд чиглэсэн, хууль дээдэлсэн ухаалаг төрийн зарчмыг хэрэгжүүлэх нь зүйтэй хэмээн үзэж 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдөр “Том төрөөс ухаалаг төр рүү” санаачилгыг хэрэгжүүлэх тухай” 52/32 дугаар зөвлөмж гаргасан. Энэхүү зөвлөмжөөр Монгол Улсын Ерөнхийлөгчид Ухаалаг төрийн зарчмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, манлайллаар хангаж ажиллах, Ухаалаг төрийн зарчмыг хэрэгжүүлэх үндэсний болон улс төрийн зөвшилцлийг бүрдүүлэхийг зөвлөмж болгосон.

Монгол Улсын Их Хуралд Ухаалаг төрийн зарчмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар болон бусад хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэн яаралтай хэлэлцэн батлах, Хууль тогтоох, хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ухаалаг төрийн зарчмыг баримтлах, түүнд нийцээгүй хууль тогтоомжийн төслийг хууль санаачлагчид нь буцаахыг зөвлөмж болгосон.

Монгол Улсын Засгийн газарт Бүрэн эрхээ хэрэгжүүлэх болон хууль санаачлах, шийдвэр гаргахдаа ухаалаг төрийн зарчмыг гүйцэтгэх засаглалын бүх шатанд чанд баримтлах, Бизнес, эдийн засгийг идэвхижүүлэх, эдийн засгийн гадаад хамаарлыг багасгах, үйлдвэрлэл, хувийн хэвшлийг дэмжих, төрийн аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах, Иргэд, хувийн хэвшил, мэргэжлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдэнд төрийн шаардлагатай ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр шилжүүлэх замаар төрийн үйлчилгээг хэмнэлттэй, үр ашигтай болгох, Төрийн өмчийн барилгыг тодорхой нөхцөлөөр худалдах, хувийн өмчийн барилгыг түрээсээр ашиглах замаар тодорхой яам, агентлаг, төрийн байгууллагын үйл ажиллагааг нэгдсэн байршил, үйлчилгээ, сүлжээнд хамруулах, Төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэрийн нэгдсэн санг бүрдүүлж нээлттэй бөгөөд бүртгэл, хяналттай болгох, Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, цаашид ийм шийдвэр гаргуулахгүй байхыг зөвлөмж болгосон.

Төрийн байгууллагуудад Байгууллагадаа ухаалаг төрийн зарчмыг нэвтрүүлэх талаар хэлэлцүүлэг явуулж, 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тодорхой ажлыг хариуцах эзэн, тодорхой хугацаатайгаар тусган хэрэгжүүлж, дээд шатны болон аудитын байгууллага, олон нийтэд тайлагнахыг зөвлөмж болгов.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2013 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд суудалтай намын бүлгийн гишүүд, бие даагч гишүүдтэй уулзаж “Том төрөөс ухаалаг төр рүү” шилжих асуудлаар нээлттэй санал солилцсон. Ухаалаг төрийг дэмжих Тунхагт, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны арваннэгдүгээр сарын 16-нд дэвшүүлсэн “Том төрөөс ухаалаг төр рүү” шилжих зорилтыг бүрэн дэмжиж, дээрх зорилтын хүрээнд төрийн тогтолцоо, үйл ажиллагааг ардчилал зах зээлийн зарчимд нийцүүлэн боловсронгуй болгох, төрийн нэгдсэн бодлого, үйл

ажиллагааны уялдаа холбоог хангах, төрийн албаны зохион байгуулалт үйл ажиллагааг шинэчилж, төрийн албаны бүх шатанд хариуцлагын тогтолцоог бий болгох, төрийн үйлчилгээний чадавхийг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх, төрийн зүгээс бизнесийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг халах, улс төрийг бизнесийн нөлөөллөөс ангид байлгах, авлигатай хийх тэмцлийг эрчимжүүлэх, үндэсний үйлдвэржилтийг дэмжих, өмчийн эрхийг баталгаажуулан хувийн хэвшлийг дэмжсэн эдийн засгийн өсөлтийг хангах, хуулийн засаглал бүхий оролцоог дэмжсэн төрийн бүтцийг бий болгох, судалгаанд суурилсан шийдвэр гаргаж төрийн үйлчилгээ үзүүлдэг болох, гэрээний сахилгыг дээдлэн мөрдөхийг хэвшүүлэх, шууд ардчилал болон орон нутгийн хөгжлийн санг дэмжих, үндэсний хөгжлийн урт хугацааны бодлогыг хуульчлан тодорхойлох, сонгуулийн хууль тогтоомжийг төгөлдөржүүлэх, мэдээллийн технологи нэвтрүүлэх зэрэг орчин үеийн өрсөлдөх чадвартай төрийн цогц шинэтгэл хийх талаар тууштай хамтран ажиллахаа илэрхийлж, Үндэсний эв нэгдэл, зөвшилцөл, улс төрийн шинэ соёл хэвшүүлэхийг сайшааж энэхүү Тунхагт нэгдэж байна” гэж Улсын Их Хурлын гишүүд гарын үсэг зурсан.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн “Том төрөөс ухаалаг төр рүү” шилжих санаачилгын хүрээнд хийгдэх хууль зүйн бодлогын шинэтгэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө баталлаа. Төлөвлөгөөнд дараах чиглэлүүдийг хамарсан 42 хуулийн төсөл багтсан. Үүнд:

1. Төрийн үйл ажиллагааны нэгдмэл байдал, бодлогын уялдааг хангах чиглэлээр;
2. Төрийн албаны эрх мэдлийг хумих, хариуцлагажуулах чиглэлээр;
3. Төрийг тунгалагжуулах чиглэлээр;
4. Хүний эрхийг хамгаалах чиглэлээр;
5. Хуулийн засаглал тогтоох чиглэлээр;
6. Төрийг хүртээмжтэй, нээлттэй болгож, иргэний оролцоог хангах чиглэлээр;
7. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих чиглэлээр;
8. Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалахын чиглэлээр;
9. Бусад чиглэлээр.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийг "Нээлттэй шүүх" болгох төслийг хэрэгжүүлсэн.

"Шүүх эрх мэдлийн шинэчлэл ба шударга ёс" үндэсний хоёрдугаар чуулган болох "Хуулийн засаглал ба шударга ёс" үндэсний чуулганыг 2013 оны 05 дугаар сарын 17-нд зохион байгуулж шүүх эрх мэдлийн шинэтгэл, шүүхийн багц хуулийн хэрэгжилт, шүүхийн захиргааны өөрчлөлт, цаашдын чиг хандлагын талаар, Эрүүгийн хуулийн шинэтгэл, боловсруулж буй хуулийн төслүүдийн танилцуулга, Авлигатай тэмцэх зорилгоор хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, тус үйл ажиллагааг эрчимжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх арга зам, авлигатай тэмцэх үндэсний стратегийн төслийн танилцуулга, Иргэдэд эрх зүй, улс төр, эдийн засгийн суурь үндсэн боловсролыг олгож, хууль дээдэлдэг, шударга иргэдийг хэрхэн бэлтгэх талаар тус тус хэлэлцлээ.

Иргэний оролцоотой шийдэл

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Манай ашигт малтмалын ихэнх нь цүнхний ашигт малтмал болжээ. Цүнхнээс цүнхэнд, гараас гар дамжиж Монголын ард түмний баялагтаа эзэн байх эрх хохирч байна. Хэдхэн этгээд, зохион байгуулалттай бүлэглэлүүд завшиж байна. Энэ байдлыг өөрчлөх хэрэгтэй” хэмээн 2010 оны 04 дүгээр сарын 20-нд Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд болон тухайн салбарын яам, агентлагийн дарга, мэргэжилтнүүдтэй уулзахдаа онцгойлон анхааруулсан байдаг.

2009 оны байдлаар Монгол Улсын нутаг дэвсгэр дээр олгогдсон ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо 5189-д хүрч тусгай зөвшөөрөл олгогдсон газар нутаг нийт газар нутгийн 44 хувийг хамарсан байв.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж энэ байдалд дүгнэлт хийн “Ашигт малтмалын хайгуулын болон тусгай зөвшөөрлийг шинээр олгох, шилжүүлэхийг хориглох тухай хууль”-ийн төслийг 2010, 2011, 2012 онд тус тус санаачилж Улсын Их Хуралд өргөн барьснаар Улсын Их Хурал баталсан. Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн баталж, дагаж мөрдөх хүртэл сүүлийн хуулийг мөрдөх болно. Өөрөөр хэлбэл, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгох шилжүүлэхийг хориглосон байдал өнөөдрийг хүртэл үргэлжилж байна.

Эрдэс баялгийн талаар төрийн бодлого олигтой зохицуулалтгүй байсан нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдалд аюул учруулахуйц ноцтой хэмжээнд хүргэсэн юм. Үүнтэй холбоотойгоор эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсгийг 2011, 2013 онд байгуулан ажиллуулсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар 2011 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр “Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт, үр нөлөө, цаашид авах арга хэмжээ”, 2011 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр “Геологи, уул уурхайн үйл ажиллагаа, байгаль орчны нөхөн сэргээлт, олон нийтийн оролцоо”, 2013 оны 02 дугаар сарын 26-ны өдөр Ашигт малтмалын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын санал солилцох уулзалтыг Иргэний танхимд тус тус зохион байгуулж иргэд, мэргэжилтэн, судлаачдын гаргасан саналыг төсөлд тусгасан.

Монгол Улсын Их Хурлаас 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай” 18 дугаар тогтоолоор төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг баталж, энэхүү бодлогын зарчим, зорилтод нийцүүлэн эрдэс баялгийн салбарын холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулан хэрэгжүүлэх; мөн энэхүү бодлогод тусгасан зорилт, чиглэлийг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөв, төрийн мөнгөний бодлого, дунд, урт хугацааны төлөвлөлтөд тусгуулан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгав.

Эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах нэгдсэн бодлоготой болж, “Ашигт малтмалын тухай” хууль батлагдсанаар Монгол Улсын үндэсний баялгийг монголчууд бид нөөцөндөө түшиглэн зүй зохистой ашиглах, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, энэ салбарт Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хангах, баталгаажуулах ихээхэн ач холбогдолтой болно.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачилгаар “Хүчирхийллийн эсрэг нэгдэцгээ” уулзалт 2013 оны 12 дугаар сарын 20-нд боллоо. Уулзалт дээр Монгол Улсын Ерөнхийлөгч үг хэлж өөрийн байр байр сууриа илэрхийлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2010 онд ард түмэндээ хандан архи хэрэглэхгүй байх, архины хэрэглээнээс татгалзахыг уриалсан юм. Энэхүү уриалгыг хувь хүн, гэр бүл, төрийн болон төрийн бус байгууллагынхан талархан хүлээн авч уриалгыг дэмжиж “Архигүй Монголын төлөө хамтдаа” үндэсний хэмжээний сүлжээ байгуулсан бөгөөд энэ сүлжээний үйл ажиллагаа өдрөөс өдөрт хүрээгээ тэлж, 3000 залууг архинаас татгалзахад нь тусалсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан “Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулсан төсөл” боловсруулах, “Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хоёрдахь хөтөлбөр”-ийг боловсруулах ажлын хэсгүүдийг байгуулж ажиллуулаад 2013 онд Хууль зүйн яаманд хуулийн төсөл, танилцуулга, үзэл баримтлал, бусад хуульд орох нэмэлт, өөрчлөлтийн төслийг, харин үндэсний хөтөлбөрийн төсөл, танилцуулгыг Эрүүл мэндийн яаманд тус тус хүлээлгэн өгсөн.

2012 оны 05 дугаар сарын 18-нд Нью-Йорк хотноо дуудлага худалдаанд орох гэж байсан Монгол Улсаас хулгайлагдсан 70 гаруй сая жилийн настай Тарбозавр Батаар үлэг гүрвэлийн олдворыг Монгол Улсын Ерөнхийлөгч улсынхаа нэрийн өмнөөс нэхэмжлэл гарган шуурхай ажилласны үр дүнд 2013 оны 05 дугаар сарын 18-нд эх орондоо буцаан авчирлаа. Үүний дараа Сүхбаатарын талбайд үлэг гүрвэлийн түр музей нээж олдворыг байрлуулан иргэд олон нийтэд сонирхуулсан юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилан боловсруулж буй хуулийн төслийн талаар хэлэлцүүлэг хийхээс гадна өмнө гарсан шийдвэрийн хэрэгжилтийн талаар олон нийтийн хүсэлтийн дагуу нээлттэй хэлэлцүүлгүүдийг хийж иргэдээ сонсож, иргэдтэйгээ хамтран асуудлаа шийдвэрлэх зарчмыг баримтлан ажиллаж байна.

Иргэний танхимд 77 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулахад холбогдох ажлын хэсгүүд, төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагуудтай хамтран ажилласан бөгөөд нийтдээ 3917 иргэн оролцсон байна. Иргэний танхимд зохион байгуулсан 77 удаагийн хэлэлцүүлгээр 114 илтгэл хэлэлцсэн. 2013 оны байдлаар улсын хэмжээнд 317 Иргэний танхим байгуулагдаад байна.

Иргэний танхимд хэлэлцүүлэг зохион байгуулах явцад зарим хэлэлцүүлэгт Монгол Улсын Ерөнхийлөгч өөрийн биеэр оролцож ажиллаж байгаа төдийгүй төр засгийн удирдлага аймаг, нийслэлийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт орон нутагтаа Иргэний танхим байгуулан, гаргах гэж буй шийдвэрийн төслийн талаар иргэдэд мэдээлэл өгч тэдний санаа бодлыг сонсож ажиллахыг байнга зөвлөж байна.

Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимаар төслийн талаархи хэлэлцүүлэг хийхдээ уг хэлэлцүүлэг болохоос 3-7 хоногийн өмнө олон нийтэд мэдээллийн бүх хэрэгслээр /телевиз, FM радио, сонин, интернет веб хуудас/-ээр зар мэдээлэл хүргэж тэдний санал, хэлэлцүүлэгт оролцох бүртгэлийг цахим шуудангаар, факс, телефон утсаар, иргэдийг хүлээж авах байраар биечлэн хүлээн авч иргэдийг аль болох өргөн

хүрээтэй хамруулах зорилго тавьж тэдний саналыг авч иргэдээ сонсож ажиллаж байна.

### Бүтээгчдээ дэмжсэн бодлого

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв нь 2010 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар үүсгэн байгуулагдсан. Төвийн үндсэн судалгааны ажил нь Монгол Улсын өрсөлдөх чадварыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу тодорхойлж, нэгдсэн ойлголтыг бүрдүүлэхэд чиглэдэг. Дэлхийн өрсөлдөх чадварын судалгааны төвтэй хамтран жил тутмын Монгол Улсын өрсөлдөх чадварын бие даасан иж бүрэн тайланг 4 дэх жилдээ гаргаад байна. /2009-2013 он/. 2012 онд Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв анх удаа орон нутгийн хөгжлийг үнэлж, аймгуудын өрсөлдөх чадварын өнөөгийн төвшинг судалж “Аймгуудын өрсөлдөх чадварын анхдугаар тайлан”-г гаргаад байна. Аймгуудын өрсөлдөх чадварыг эдийн засаг, засаглал, бизнес, дэд бүтцийн нийт 180 шалгуур үзүүлэлтээр цогц байдлаар үнэлсэн юм.

Аймгуудын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд автозам, дэд бүтцийг хөгжүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, авлига, хүнд суртлыг халах, эрүүл мэнд, боловсролын тогтолцоог сайжруулах, уул уурхайн орлогыг зохистой ашиглах зэрэг нийтлэг асуудлуудыг зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай нь судалгаанаас харагдаж байна. Иймээс цаашид орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлогыг тодорхойлж төлөвлөхдөө олон улсын аргачлалаар өрсөлдөх чадварыг судалж тооцоолдог мэргэжлийн байгууллагын гаргасан судалгааны үр дүнг үндэс суурь болгох нь үндэсний хөгжлийн цэгцтэй бодлогыг бий болгоно гэж Монгол Улсын Ерөнхийлөгч үзэж байна.

### Байгальд ээлтэй хөгжил

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 63 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангах ажлыг хэрэгжүүлэх, түүнд идэвхитэй оролцох, дэмжлэг тусалцаа үзүүлэх талаар яам, агентлагууд, аж ахуйн нэгж байгууллагууд, төрийн бус байгууллагууд, аймаг орон нутаг болон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, 9 удаа бүх орон даяар “Мод тарих үндсэний өдөр”-ийн арга хэмжээг зохион явуулаад байна.

2009 онд “Мод тарих үндсэний өдөр”-өөр орон даяар мод тарих үйл ажиллагаанд 3812 албан байгууллага, аж ахуйн нэгж, 70000 иргэн идэвхтэй оролцож, нийт 1.194.300 мод, бут сөөг тарьсан.

2010 оны 05 дугаар сарын 15-ны өдөр, 2010 оны 10 дугаар сарын 09-ний “Мод тарих үндсэний өдөр”-өөр орон даяар мод тарих үйл ажиллагаанд 7689 албан байгууллага, аж ахуйн нэгж, 226453 иргэн идэвхтэй оролцож, нийт 1.754.000 мод, бут сөөг тарьсан.

2011 онд улс орон даяар мод тарих үйл ажиллагаанд 4669 албан байгууллага, аж ахуйн нэгж, 156700 иргэн идэвхтэй оролцож, 1.476.900 мод, бут сөөг тарьсан.

2012 онд улс орон даяар мод тарих үйл ажиллагаанд 7284 албан байгууллага, аж ахуйн нэгж 191900 иргэн идэвхтэй оролцож нийт 1.562.900 мод, бут сөөг тарьсан.

2013 онд улс орон даяар мод тарих үйл ажиллагаанд 11324 албан байгууллага, аж ахуйн нэгж, 198000 иргэн идэвхтэй оролцож нийт 1.212.600 мод, бут сөөг тарьсан.

Ийнхүү зарлиг гарсан хугацаанаас хойш 9 удаагийн нэгдсэн арга хэмжээний үеэр нийт 6.006.400 ширхэг мод тарьсан байна.

Газар албадан чөлөөлөх тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг Нийслэлийн удирдлагуудтай хамтран 2013 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд зохион байгуулсан. Мөн “Нийслэл хотыг дахин хөгжүүлэх талаар” болон “Гэр хорооллыг дахин төлөвлөж хөгжүүлэх нь” хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Гэр хорооллын инженерийн дэд бүтцийг хөгжүүлснээр иргэд өөрийн эзэмшлийн хашаа, байшингаа орчин үеийн, гадаад улсын жишгийн дагуу хөгжүүлэх боломж бий болно. Гэр хороололд тулгамдаж байгаа бүх асуудлыг энэ хэлэлцүүлгээр хөндөн ярилцаж цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон.

“Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн эрх зүйн байдлын тухай” хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн боловсруулсан хуулийн төслийг 2013 оны 02 дугаар сарын 21-ний өдөр Иргэний танхимаар хэлэлцүүлсэн. Хэлэлцүүлгээр гарсан санал, зөвлөмжийг хуулийн төсөлд тусган Засгийн газраас санал авахаар хүргүүлсэн. Хуулийн төслийг дэмжих бололцоогүй, Ерөнхийлөгчийн зарлигаар Засгийн газарт чиглэл өгөх нь зүйтэй гэсэн албан бичиг ирсэн. Үүний үндсэн дээр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2013 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Засгийн газарт чиглэл өгсөн 178 дугаар зарлиг гаргасан. Уг зарлигаар Улаанбаатар хотод Үндэсний цэцэрлэгт хүрээлэнг, хот тосгон, аймаг, сумын төвд цэцэрлэгт хүрээлэн байгуулах, тэдгээрийг сэргээн засварлах, хүрээлэнгүүдийн үйл ажиллагааны зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгах, эрх зүйн орчныг тодорхой болгохыг Засгийн газарт чиглэл болгосон.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 181 дүгээр зарлигаар Төрийн тахилгатай уул хайрханы тэнгэрийг тайх төрийн ёслол үйлдэх хуваарь (2013-2032 он)-г баталсан билээ. Энэхүү хуваарийн дагуу тахилгыг таван жилд нэг удаа үйлдэхээр болсон бөгөөд 2013 онд Их Тахилгат хайрхан, Алтан хөхий уулын тэнгэрийг тайх төрийн ёслолыг үйлдэв.

### Дэлхийд нэртэй Монгол

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын санаачилгаар EBI хүрээлэнгээс Мьянмарын сэтгүүлчдийн уулзалт-сургалтыг зохион байгууллаа. Уулзалт-сургалтад Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсын хамгийн нөлөө бүхий хэвлэл, мэдээлийн байгууллагыг төлөөлсөн 20 сэтгүүлч хамрагдлаа.

Монгол Улсын ардчиллын туршлага, шилжилтийн үеийн улс төр, нийгэм, эдийн засгийн байдал, ардчилсан, чөлөөт сонгууль явуулж парламентын засаглал тогтоосон, ардчилсан Үндсэн хуулийг баталсан үйл явц, өмч хувьчлалыг хэрхэн зохион байгуулсан, уул уурхайн салбарын хөгжил зэрэг өнгөрсөн 24 жилийн туршлагыг судалснаас гадна шүүхийн шинэтгэл, мөнгө санхүүгийн бодлого, эрүүл мэнд, боловсролын тогтолцоо, хэвлэлийн эрх чөлөө зэрэг сэдвээр лекц сонсч, илтгэгчидтэй харилцан ярилцлаа.

Эх түүх, үндэсний соёлын өв сангаа өргөн хүрээнд судлах, нээн илрүүлэх, баталгаажуулах, судалгааны эргэлтэд оруулах, энэхүү ажилд гадаад орны



эрдэмтдийг татан оролцуулах, тэдэнтэй нягт хамтран ажиллах, Монгол Улсад болон гадаад оронд монгол судлалыг хөхиүлэн дэмжих, монгол судлалыг хөрөнгө санхүүгийн хувьд ивээн тэтгэх замаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг идэвхжүүлэх, залуу судлаачдыг урамшуулах, тэдний бүрэлдэхүүнийг бэлтгэх, чадавхижуулах, монгол судлалын үр өгөөжийг нэмэгдүүлэх, дэлхий дахинд сурталчлах зорилгоор 2012 оны 01 дүгээр сарын 17-ний өдөр “Монгол судлалыг дэмжих сан байгуулах тухай” Засгийн газарт чиглэл өгсөн зарлиг гаргасан. Засгийн газар 2012 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн “Үндэсний хөтөлбөр батлах тухай” (Монгол судлалын) 56 дугаар тогтоолоороо Монгол судлалыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталсан. 2013 онд Монгол судлалаар суралцах гадаадын иргэнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлэг олгох журам баталж, нийт 11 судлаач оюутнуудад тэтгэлэг олгосон.

### Бусад

Монголын түүхийг бодит байдал, болсон үйл явдлаар нь үнэн зөв бичиж, их дээд сургууль болон ерөнхий боловсролын сургуулийн түүхийн хичээлийн хөтөлбөр, сурах бичигт тусгах, оюутан, сурагчдад түүхийн бодит мэдлэг олгох зорилгоор “Монголын түүх” хөтөлбөр;

Монголын ард түмний уламжлалт соёл, эрдэм, ур ухааныг цагийн аяс, амьдралын хэв маягийн өөрчлөлтөөс үүдэн баларч гээгдэхээс сэргийлэх, тэдгээр үнэт зүйлсийг тээж яваа иргэдийг тодруулах, дэмжих, ур ухааныг нь дэлгэрүүлэх, хойч үедээ өвлүүлэх зорилгоор “Улсын эрдэнэ” хөтөлбөр;

Иргэдийн сайн санааны болон бусдад туслах санаачилгыг дэмжих зорилгоор “Ардын элч” хөтөлбөр боловсруулах Ажлын хэсгүүдийг салбарын төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачдын бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулан ажиллуулж байна.

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР

Танилцсан: Тамгын газрын дарга

П.Цагаан

Хянасан: Тамгын газрын дэд дарга

Б.Нэргүй

Боловсруулсан: ЗА-ны ахлах референт  
2014.07.24.



Б.Цэрэнжигмэд